



# **“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2018 он**

## “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2018 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

“Монгол шуудан” ХК нь 2018 онд дараах зорилго, зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

**ЗОРИЛГО:** БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ОРЛОГЫН ШИНЭ ЭХ ҮҮСВЭРИЙГ БИЙ БОЛГОХ


**ЗОРИЛТ:**

- ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР АШГИЙГ САЙЖРУУЛАХ
- ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ
- САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭХЛҮҮЛЭХ
- КОМПАНИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИНГ ХАНГАН АЖИЛЛАХ

Тус компани нь дээр дурдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлуудыг 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хагас жилээр тодотгон, биелэлтийг тооцож ажиллав.

2018 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг дор дурдсанаар үндсэн 2 агуулгын дагуу дэлгэрэнгүй тайлагнаж байна.

- 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- КОМПАНИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



## НЭГ. ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР АШГИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“Монгол шуудан” компани нь шуудангийн үйлчилгээний 39 салбар, 22 аймаг, дүүргийн газар, 331 сумдын салбараар дамжуулан, хотын дотор болон орон нутгийн шуудан бэлтгэх, ялган боловсруулах, солилцох, тээвэрлэх, хүргэж гардуулах зэрэг бүх төрлийн дотоод шуудангийн үйлчилгээ үзүүлэхээс гадна дэлхийн шуудан холбооны 192 гаруй оронтой улс хоорондын шуудан, түүний дотор 116 оронтой буухиа шуудан /EMS/ солилцох үйлчилгээг үзүүлж байна.

### 1.1. Хэвлэл захиалгын үйлчилгээний талаар

Тус компани нь хэвлэл захиалгыг нэмэгдүүлэх зорилгоор [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) сайт болон фэйсбүүк хуудас, өдөр тутмын сонин болон сурталчилгааны самбарт мэдээлэл байршуулж, олон нийтэд сурталчлан таниулж ажиллалаа.

2018 оны эхний хагас жилд нийт 1,3 тэрбум төгрөгийн хэвлэл захиалга авч, үүнээс нийт шимтгэлийн орлого болох 127,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хэвлэл захиалгын орлогыг бүтцийн хувьд авч үзвэл, нийт орлогын 61 хувь буюу 786,3 сая төгрөгийг хөдөө, орон нутгаас, үлдсэн 39 хувь буюу 513,7 сая төгрөгийг нийслэл Улаанбаатар хотоос төвлөрүүлж байна. Цаашид орон нутгийн хэвлэл захиалгын борлуулалтыг бууруулахгүй байх, мөн нийслэл Улаанбаатар хотын хэвлэл захиалгын үйлчилгээг илүү далайцтай болгох дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. /График 01/




График 01. Хэвлэл захиалгын орлогын бүтэц

#### 1.1.1. Дотоод хэвлэл захиалга

Дотоод хэвлэл захиалгын хувьд, 99,6 мянган ширхэг буюу 1,3 тэрбум төгрөгийн хэвлэл, 5,9 мянган ширхэг буюу 48,8 сая төгрөгийн номын захиалга авч, үүнээс нийт шимтгэлийн орлого болох 127,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулж үзэхэд, хэвлэл 950,0 төгрөгөөр өссөн бол номын захиалга 1,8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна./Хүснэгт 01/

Хугацаа	Солилцооны тоо		Мөнгөн дүн		Шимтгэлийн орлого	
	Хэвлэл	Ном	Хэвлэл	Ном	Хэвлэл	Ном
2017 оны ЭХЖ	108.085	7.179	1,31 тэр бум	55,4	117,5	13,8
2018 оны ЭХЖ	99.692	5.975	1,3 тэр бум	48,8	118,4	12,1
<b>Нийт</b>						

Хүснэгт 01. Дотоод хэвлэл захиалгын үзүүлэлтүүд

Хэвлэл захиалгын гарын авлагыг 2018 оны эхний хагас жилийн байдлаар 25 мянган ширхэгийг хэвлүүлж, түүний өртгийг бууруулах зорилгоор реклам байршуулах, өнгө үзэмжийг сайжруулах, борлуулалт сайтай номыг бүртгэлд оруулах, хэт хуучирсан, нийлүүлэх боломжгүй номуудыг хасах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Гарын авлагын орлого нь нийт 5,4 сая төгрөг байна.

### 1.1.2.Онлайн хэвлэл захиалга

Хэвлэл захиалгыг боловсронгуй болгох, бодит өртгийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд онлайн хэвлэл захиалгын [www.postnews.mn](http://www.postnews.mn) сайтыг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэж, хэвлэл захиалгыг онлайнгаар авч эхлэн, нийт 451 төрлийн 9,2 сая төгрөгийн хэвлэл захиалга авч, үүнээс 694,8 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна. /Хүснэгт 02/

Байршил	Тоо ширхэг	Нийт Үнэ	Шимтгэлийн орлого
Орон нутаг	208	4,699,818	373,796
УБ хот	243	4,490,811	321,030
Нийт	451	9,190,629	694,826

Хүснэгт 02. Онлайн хэвлэл захиалгын үзүүлэлтүүд

Хэвлэл захиалга цахимжсантай холбоотойгоор гарын авлагыг файл хэлбэрээр захиалагч нарт хүргэхээс гадна [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) сайтаар болон фэйсбүүк хуудсанд татаж авах боломжтойгоор байршуулсан.

### 1.1.3.Гадаад хэвлэл захиалга

Тайлант хугацаанд нийт 454 ширхэг, 69,6 сая төгрөгийн гадаад хэвлэл захиалж, үүний шимтгэлийн орлого болох 31,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Түүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, гадаад хэвлэл 17,3 сая төгрөгөөр, шимтгэлийн орлого 5,2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Гадаад хэвлэл захиалга өссөн гол шалтгаан нь англи хэвлэлийн захиалга шинээр авч эхэлсэнтэй холбоотой юм. /График 02/

## Гадаад хэвлэл захиалга




График 02. Гадаад хэвлэл захиалгын харьцуулсан үзүүлэлт

## 1.2. Бичиг захидлын үйлчилгээний талаар

Шуудангийн үндсэн үйлчилгээний нэг болох бичиг захидлын үйлчилгээг идэвхжүүлэх ажлын хүрээнд УИХ-ын гишүүн А.Ундраатай хамтран ажиллаж, 15 мянга гаруй хэрэглэгчдэд шинэ жилийн мэндчилгээ хүргүүлж, нийт 6,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.



Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газруудаас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгүүдийн үеэр хэрэглэгчдээр ил захидал, бичиг захидал үнэгүй бичүүлэн, нийт мянга орчим хэрэглэгчдэд шуудангийн үйл ажиллагааг танилцуулж, 500 гаруй ширхэг ил захидал, бичиг захидлыг үнэгүй бичүүлж хүлээн авлаа. /Зураг 01/

Зураг 01. Хэрэглэгчдээр захидал бичүүлж байгаа нь

“Цаг хугацаагаар аялсан захидал” зохион бичлэгийн уралдааныг улс орон даяар зохион байгуулж, 8.230 мянга гаруй захидал хүлээн авч, нийт 4,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, бичиг захидал, маркийн орлого болон солилцоог нэмэгдүүлсэн. Энэхүү аяны хүрээнд “Mongolian Pen” ХХК-тай хамтран ажиллаж, 150 гаруй хүүхдүүдийг Pilot брэндийн гарын бэлгээр шагнаж урамшууллаа./Зураг 02/



Зураг 02. Шилдгийн шилдэг хүүхдүүд

Бүгд Найрамдах Итали улсын парламентын сонгууль явагдсантай холбоотойгоор Монгол Улсад оршин суугаа Итали улсын иргэдээс сонгуулийн саналыг захидлаар хүлээн авах ажлыг зохион байгуулж 1,0 сая орчим төгрөгийн орлогыг төвлөрүүллээ.

## 1.3. Марк, үнэт цаасны үйлчилгээний талаар

Аялал жуулчлалын улирал эхэлж байгаа өнөө үед жуулчид ихээр үйлчлүүлдэг таван одтой зочид буудал болох “Корпорайт”, “Туушин”, “Шангила” болон Монгол Улсын түүх дурсгалыг шингээсэн музей, үзвэрийн газрууд болох Занабазарын музей, Богд хааны


ордны музей, дүрслэх урлагын галлерей, Цонжин болдог, Чойжинламын музей болон томоохон дэлгүүрүүдэд марк, ил захидлын худалдааг төвлөрүүлэн зохион байгуулах талаар санал хүргүүлсэн бөгөөд хамтран ажиллаж эхлээд байна.

Баяр ёслолын өдрүүдэд зориулсан 8 ширхэг мэндчилгээний загварыг боловсруулж, хэвлэлтэд шилжүүлэв. /Зураг 03/



Зураг 03. Шинээр гарсан мэндчилгээний загвар

Тус компанийн үндсэн бүтээгдэхүүн болох ил захидлын загвар болон зургуудыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Ил захидлын өмнөх жилийн борлуулалтын харьцуулсан үзүүлэлтийг судлан, шинээр гарч буй ил захидлын зургийн санг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтыг хийж, цоо шинээр 64 ширхэг ил захидлыг бүтээгдэхүүн болгох ажлыг хийж гүйцэтгэв. /Зураг 04/




Зураг 04. Шинээр гарсан ил захидлын стандарт загвар

#### 1.4. Улс хоорондын шуудангийн үйлчилгээний талаар

Улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээг дэлхийн 136 оронд үзүүлдэг болсонтой холбоотойгоор сурталчилгаа байрлуулах, фейсбүүк хуудас болон вэб сайт дээр 8 төрлийн контент бэлтгэж мэдээлэх зэргээр олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.

Олон улсын буухиа шуудангийн үйлчилгээ /EMS/-ийн сурталчилгааны материалын ерөнхий агуулгын текстийг шинэчилж, монголоос англи хэл рүү хөрвүүлэн орчуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. /Зураг 05/



Зураг 05. Олон улсын буухиа шуудан /EMS/-ийн сурталчилгааны материал

Мөн 2017 оны 01 сараас 2018 оны 06 сар хүртэлх хугацааны нийт солилцооны тоог гаргаж, олон удаагийн давтамжтай илгээмж явуулж буй байгууллага, хувь хүмүүс болон илгээмж хамгийн ихээр явагддаг сарууд дээр судалгаа, шинжилгээ хийн ажиллаж байна.

### 1.5. Мөнгөний дугуйны борлуулалтын талаар

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 234,5 мянган ширхэг мөнгөний дугуй борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж, 275,3 ширхэгийг борлуулж, 41,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 6,4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. /График 03, 04, 05/




График 03. Нийт мөнгөний дугуйны орлогын үзүүлэлт




График 04. ШҮ-ний салбаруудын мөнгөний дугтуйны орлогын үзүүлэлт




График 05. Аймгийн ШҮГ-ын мөнгөний дугтуйны орлогын үзүүлэлт

Өнгөрсөн оны мөнгөний дугтуйны үлдэгдлийг гаргаж, гүйлгээ сайтай дугтуйны өнгө загварын судалгаа хийн, 10 төрлийн хуучин загвар, 10 төрлийн шинэ загвар, нийт 20 төрлийн дугтуйны загваруудыг тодорхойлж, 300,0 мянган ширхэгийг хэвлүүлэн, худалдаанд гаргаж борлууллаа. /Зураг 06/



Зураг 06. Мөнгөний дугтуйны загварууд

Мөнгөний дугтуйны орлогыг өсгөх зорилгоор худалдах үнийг 200 төгрөгөөр тогтоож, үүнээс 50 төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгох санал, санаачилга гарган батлуулсан. Мөн сүлжээ дэлгүүр болон бусад сувгуудаар борлуулах боломжийг давхар бүрдүүлж өгөв.





Зураг 07. “Миний сонголт-Монгол брэнд” нэвтрүүлэг

Цагаан сарын баярыг тохиолдуулан, “Миний сонголт-Монгол бэлэг-2018” нэвтрүүлэгт мөнгөний дугуйны тухай нэвтрүүлэг бэлтгэн оролцсоноос гадна тухайн нэвтрүүлгийг “UBS”, “Өлзий”, “Эх орон”, “Малчин”, “NTV” телевизүүд, 10 гаруй фэйсбүүкийн пэйж хуудсууд, МОСАХ-ны гишүүн 20 гаруй мэдээ мэдээллийн сайтуудаар бичлэг болон текст хэлбэрээр тавьж сурталчиллаа. /Зураг 07/

Тус компани нь 2018 оны эхний хагас жилд нийт 58 ширхэг төр болон хувийн байгууллагатай хамтран ажиллах болон үйлчилгээ үзүүлэх гэрээ хийж, хамтран ажиллаж байна.

### 1.6. Хүргэлтийн үйлчилгээний талаар

“Монгол шуудан” ХК нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүргэлтийн үйлчилгээгээр 468,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, хүргэлтийн үйлчилгээний орлого өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин нэмэгдэв.

Үндсэн үйлчилгээг хөгжүүлэх зорилгын хүрээнд Улаанбаатар хотын Автопаркийн шинэчлэл хийж, хотын доторх автомашинтай хүргэлтийн үйлчилгээг эхлүүллээ. /Зураг 08/



Зураг 08. Hyundai Porter маркийн 10 ширхэг авто машин хүлээн авч байгаа нь

“Скайтел” ХХК-ийн авлагын захидлыг гибрид шуудангаар хүргэх үйлчилгээг хийж, эхний хагас жилийн байдлаар нийт 92 ширхэг гибрид шуудан хүлээн аван, цаг хугацаанд нь гардуулж, 3,1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна. /Хүснэгт 03/

Сар өдөр	Тоо ширхэг	Орлогын дүн /төг/
I сар	25	1'001'550
II сар	25	447'040
III сар	16	628'320
IV сар	10	522'500
V сар	6	201'740
VI сар	10	315040
<b>Нийт орлого</b>	<b>92</b>	<b>3,116,190</b>

Хүснэгт 03. “Скайтел” ХХК-ийн авлагын захидлын хүргэлтийн үйлчилгээний орлогын мэдээ /сар бүрээр/

“Юнител” группийн авлагын захидлыг гибрид шуудангаар хүргэхээр гэрээ байгуулан, хамтын ажиллагааг эхлүүлээд байна.


“Мобиком” корпорацийн шинэ хэрэглэгчийн захидлыг шуудангаар хүргэх үйлчилгээ, орон нутагт авлагын захидал хүргэх ажлыг тогтвортойгоор үргэлжлүүлэн ажиллаж байна. Нийт орон нутгийн авлагын захидал хүргэлтийн үйлчилгээгээр 2018 оны эхний 5 сарын байдлаар 46 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, өмнөх оны мөн үеийнхээс 10 дахин өссөн үзүүлэлтэй байна. /Хүснэгт 04/

Сар өдөр	Тоо ширхэг	Орлогын дүн /төг/
I сар	8675	10'000'730
II сар	8022	11'000'673
III сар	6637	9'000'955
IV сар	5980	8'000'970
V сар	5728	8'000'592
<b>Нийт орлого</b>	<b>35042</b>	<b>46003920</b>

Хүснэгт 04. “Мобиком” корпорацийн авлагын захидлын хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

Татварын өрийн бичгийг гибрид шуудангаар хүргэх ажлын програм хангамжийн шийдлүүдийг тодорхойлж, нийт 2018 оны 03 сарын 15-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд 167 ширхэг гибрид шууданг хүргэж гардуулаад байна. Мөн гэрээний төсөл болон үнийн саналыг ТЕГ-т хүргүүлээд байна.

ОӨУБЕГ-тай хамтран, Монгол Улсын иргэний энгийн гадаад паспортыг иргэдийн хүсэлтийн дагуу буухиа шуудангаар хүргэх тухай гэрээний биелэлтийг хангах, цаашдын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх боломжууд болон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон саналаа хүргүүлсэн. Гэрээг шинэчлэн байгуулах талаар харилцан ашигтай шийдлүүдийг гарган, уулзалт хэлэлцээр хийж, өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлуудыг дүгнэж, илтгэх хуудсаар Иргэний бүртгэлийн газарт хүргүүлж, ОӨУБЕГ-ын шинэ орон тоо, бүтцийн зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор нийслэлийн 7 дүүрэг, 4 төвд нэг цэгээс хэрхэн хүргэлт хийх, мөн цаашид гадаад паспортыг хаягаар хүргэх үйлчилгээг идэвхжүүлэх талаар 2 тал харилцан шийдэлд хүрэхээр ажиллаж байна. /Зураг 09, Хүснэгт 05/



Зураг 09. Гадаад паспортын сургалчилгааны самбар болон тараах материал

Хугацаа	Тоо ширхэг	Орлогын дүн /төг/
I сар	57	228000
II сар	53	170000
III сар	45	195000
IV сар	90	413000
V сар	70	365000
VI сар	53	150000
<b>Нийт орлого</b>	<b>368</b>	<b>1,521,000</b>

Хүснэгт 05. Гадаад паспортын хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

Мөн ОӨУБЕГ-тай хамтран, иргэдийн цахим үнэмлэхийг нийслэлийн 9 дүүрэгт багцаар хүргэх үйлчилгээг эхлүүлэн ажиллаж байна. /Хүснэгт 06/

Сар өдөр	Ширхэгээр		Багцаар	
	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/
I сар	93	366600	152	799500
II сар	36	119700	48	383020
III сар	39	186700	66	511300
IV сар	56	224900	89	494600
<b>Нийт</b>	<b>224</b>	<b>897900</b>	<b>355</b>	<b>2188420</b>

Хүснэгт 06. Цахим үнэмлэхний хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

“Хаан банк”-ны харилцагчийн картын хүргэлт болон 90 гаруй картын төвүүдэд багцаар карт хүргэх хүргэлтийг хийж, эхний хагас жилийн байдлаар нийт 246,1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаад байна. Энэ хугацаанд 2 талын хамтын ажиллагааг сайжруулах тал дээр анхаарч, үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг тухай бүр нь шийдвэрлэж ирсэн. Гэрээний хугацаа дууссан тул гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар уулзалтыг зохион байгуулж, энэхүү уулзалтаар харилцагчийн карт хүргэх үйлчилгээний үнийн дүнд өөрчлөлт оруулан, одоо мөрдөгдөж байгаа дебит карт хүргэх үнийг 50%, орон нутагт хүргэх үнийг 30%, кредит картыг хүргэх үнийг мөн 30%, дугтуйны үнийг 110-130 төгрөг болгон нэмэгдүүлж, энэ оныг дуустал мөрдөхөөр шийдвэрлэсэн бөгөөд ирэх оны тарифыг эртнээс төлөвлөж, тохиролцон төсөвт суулгахаар боллоо./Хүснэгт 07/

Сар өдөр	Албан бичиг		Боодол		Хувь хэрэглэгч	
	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/
I сар	472	1308295	1634	4135920	29600	37122140
II сар	539	1259785	1325	5998850	25441	32542040
III сар	358	836735	1392	6211590	22654	29284420
IV сар	455	1021241	1795	8565260	372	19856288
V сар	302	647450	1509	7436550	32025	41181360
VI сар	474	1154740	1160	5355460	32208	42202800
<b>Нийт орлого</b>	<b>6228246</b>		<b>37703630</b>		<b>202189048</b>	

Хүснэгт 07. “Хаан банк”-ны картын хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

“Хас банк” ХХК-ийн харилцагчийн картыг хаягаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн, нийт 21,5 сая төгрөгийн үйлчилгээг үзүүлэв. /Хүснэгт 08/

Сар	Тоо ширхэг	Орлогын дүн /төг/
I сар	867	2800020
II сар	964	4009660
III сар	865	2943710
IV сар	1180	3516680
V сар	900	4027300
VI сар	965	4244900
<b>Нийт орлого</b>		<b>21,542,270</b>

Хүснэгт 08. “Хас банк”-ны картын хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

“Төрийн банк”-ны харилцагчийн картыг хаягаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн, нийт 8,4 сая төгрөгийн үйлчилгээг үзүүллээ. /Хүснэгт 09/

Хугацаа	Картын төв /багцаар/		Захиргаа удирдлага		Хангамж	
	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/
I сар	123	750420	280	647240	20	25740
II сар	136	859100	242	605330	1	1320
III сар	106	595440	199	409530	7	8580
IV сар	161	1044780	310	616000	50	60280
V сар	158	869000	191	414590	66	85800
VI сар	121	757900	206	544500	83	104060
<b>Нийт орлого</b>	<b>4876640</b>		<b>3237190</b>		<b>285780</b>	
			<b>8399610</b>			

Хүснэгт 09. “Төрийн банк”-ны картын хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/

“Богд банк” ХХК-тай хамтран ажиллаж, тайлант хугацаанд нийт 772,9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. /Хүснэгт 10/

Хугацаа	Тоо ширхэг	Орлогын дүн /төг/
I сар	47	58740
II сар	44	306975
III сар	33	142340
IV сар	50	117060
V сар	53	66880
	60	80960
<b>Нийт орлого</b>		<b>772875</b>

Хүснэгт 10. “Богд банк”-ны хүргэлтийн орлогын мэдээ /сар

“Замын хөдөлгөөний удирдлагын төв”-тэй хамтран ажиллаж, зөрчил гаргасан тээврийн хэрэгслийн жолоочийн 97,9 мянган ширхэг торгуулийн хуудсыг эзэмшигч, өмчлөлийн хаягаар хүргэн өгч, нийт 138,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. /Хүснэгт 11/

Сар өдөр	Торгуулийн хуудас		Багц	
	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/	Тоо ширхэг	Орлогын дүн /төгрөг/
I сар	12194	17120376	219	438000
II сар	17457	24509628	289	578000
III сар	16021	22493484	236	472000
IV сар	20771	29162484	293	586000
V сар	21351	29976804	298	596000
VI сар	8683	12190932	106	212000
<b>Нийт орлого</b>		<b>135453708</b>		<b>2882000</b>

*Хүснэгт 11. Торгуулийн хуудасны хүргэлтийн орлогын мэдээ /сар бүрээр/*

Интернет худалдааны хүргэлтийн үйлчилгээг эхлүүлэх суурь дэд бүтэц болох бүртгэл, мэдээллийн програм хангамжийг яаралтай хийлгэх шаардлагатай ба програмын үндсэн модель, зарчмын талаарх нарийвчилсан UI боловсруулах ажил хийгдэж байна. Бусад бэлтгэл ажлын хүрээнд E-март, Шопмн, Сами групп зэрэг байгууллагуудтай урьдчилсан байдлаар уулзаж, цаашид хамтран ажиллах талаар албан бус тохиролцоонд хүрсэн.

Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар интернет худалдааны хүргэлтийн тарифыг батлуулж, интернэт худалдааны хүргэлтийг хийх талаар ажлын хэсэг байгуулсан тул санхүү хөрөнгө оруулалт, техникийн болон ажиллах хүчний нөөц боломж зэрэг асуудлуудыг нарийвчлан судлан ажиллаж эхэлсэн.



Хайрын хурим загварын салонтой хамтран ажиллаж, Монголын анхны хуримын хувцасны загварын хүлээн авалтад хүрэлцэн ирсэн тусгай зочдын урилгыг тусгай хүргэлтээр хүргэх ажлыг зохион байгууллаа./Зураг 10/

*Зураг 10. Шуудангийн илгээмж гардуулж буй нь*

Улсын Их Хурлын Тамгын газраас нийт 1,608 ширхэг илгээмжийг аймаг, нийслэл, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газар, яамдууд, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд, мөн түүний бусад харъяа байгууллагуудад хүргэж гардуулан, 3,0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллалаа.

### **1.7. Үндсэн үйлчилгээг түшиглэн, зах зээлд хэрэгцээтэй бусад болон нэмэлт үйлчилгээг хөгжүүлэх талаар**

Шинэ нисэх онгоцны буудалд улс хоорондын шуудан ялган боловсруулах төв байгуулах төсөл боловсруулан ХХМТГ, Нийслэлийн эрх бүхий байгууллагад, Засгийн газрын түвшинд танилцуулан дэмжүүллээ.

Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, байгууллагын үйл ажиллагааг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, хурдан шуурхай болгох санал санаачилга гаргаж, цаашдын боломжуудыг тодорхойлох зорилгын хүрээнд “Хотын салбаруудын зохион байгуулалтыг оновчтой болгох”, “Хөдөө орон нутагт борлуулах илгээмжийн барааг идэвхжүүлэх, нэгдсэн зохион байгуулалтанд оруулах” гэсэн 2 чиглэлээр “Ажлын хэсэг” байгуулан ажиллаж байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан, “Flower” компанитай хамтарч, цэцгийн худалдаа гаргаж, цэцэг худалдан авсан хэрэглэгч бүрт мэндчилгээ дагалдуулж борлууллаа. /Зураг 11/



Зураг 11. Цэцгийн худалдааны сурталчилгааны самбар

“Лояалти” урамшууллын картыг нэвтрүүлэхэд бэлэн болсон ба санхүүгийн програмын хөгжүүлэлт хийх ажил хүлээгдэж байна.

Хөдөө орон нутгийн орлого нэмэгдүүлэх, илгээмжийн барааны өртгийг бууруулах зорилгоор “Таван богд” ХХК, “Макс эксем” ХХК, “Дижитал сервис” ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, аймгийн шуудангийн үйлчилгээний газруудыг хямд үнэтэй бичгийн цаас, принтерийн хот борлуулах боломжоор ханган ажиллаж, нийт 20,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүллээ.

Аймгуудын ШҮГ-т “ТАНСАГ ГОЁЛ” хонхны захиалгыг Монгол Улсын их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч оюутан залуусын амьдралын алтан дурсамжийг үлдээх төгсөлтийн баярт зориулсан баярын хонхыг ханган нийлүүлэх зорилгоор нийт ШҮГ болон ШҮС-аар 1,5 мянган ширхэг хонхны захиалга авч, 1,5 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулсан.

Ребрендингийн ажлын хүрээнд Дархан, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудын шуудангийн үйлчилгээний газар, Улаанбаатар хотын ШҮ-ний 51, 36, 49, 21 дүгээр салбаруудыг жишиг салбар болгох ажлыг эхлүүлж, план зураг болон төлөвлөгөөг гарган ажиллаж байна. /Зураг 12/



Зураг 12. ШҮ-ний 51-р салбарын план зураг

### 1.8. Бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах талаар

Компанийн нэр хүндийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор 7 удаагийн телевизийн нэвтрүүлэг, 1 радиогийн нэвтрүүлэгт оролцож, 6 төрлийн 61,0 мянган ширхэг сурталчилгааны материал хэвлүүлэн гаргаж тараасан ба гэрээт сонин хэвлэлүүдэд 11 төрлийн контентийг 70 удаа хэвлүүлэн гаргасан.

Гэр бүлийн радио 102.5 “Гэр бүлийн өдөр”-ийн ээлжит нэвтрүүлэгт оролцож, компанийн үйл ажиллагаа болон шинээр нэвтрүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг танилцуулан, захидал, түүний соёл, хэрэглээ, захидлын аяны талаар олон нийтэд мэдээллийг хүргэсэн.

Шуудангийн бүх төрлийн үйлчилгээг сурталчлан таниулах, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх зорилгоор өдөр тутмын сонин, чөлөөт хэвлэлүүд, мөн гэрээт сэтгүүлүүдэд мөнгөний дугтуй, мэндчилгээ, хэвлэл захиалга, дотоод илгээмжийн урамшуулал, Өвлийн өвгөний захидлын уралдаан зэрэг шуудангийн үндсэн үйлчилгээний талаар мөн Ард санхүүгийн нэгдлийн өдөрлөг, Монголын эдийн засгийн форум, Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага, JCI central салбар, Ил тод байдал залуусын нүдээр төслийн багийн хамт олон зэрэгтэй хамтран ажиллах санамж бичиг зурсантай холбоотойгоор мэдээ 20 төрлийн контентийг давхардсан тоогоор 82 удаа хэвлүүлэн гаргасан.

Бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор мөнгөний дугтуй, логистик үйлчилгээ, буухиа шуудангийн үйлчилгээний талаар 9 төрлийн 65,0 мянган ширхэг сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргэсэн. Түүнчлэн логистик үйлчилгээний 10,0 ширхэг, гадаад паспортын хүргэлт болон жолооны үнэмлэх хүргэлтийн үйлчилгээний 25,0 мянган ширхэг, олон улсын буухиа шуудангийн үйлчилгээний 8,0 ширхэг сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргэсэн ба төв шуудангийн гадна талын 2 самбар дээр гадаад хэвлэл захиалга, “Цаг хугацаагаар аялсан захидал” хулдаасан хэвлэлийг байршуулж, 1,000 ширхэг захидлын аяны брошюр хэвлүүлэн тараасан.

*Facebook page болон байгууллагын цахим хуудасны идэвхжүүлэлт*

Компанийн [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) сайт дээр бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой цаг үеийн онцлог байдлаас шалтгаалан коверийг шинэчилж, загваруудыг боловсруулан ажиллаж байна. /Зураг 13/



Зураг 13. Ковер зургийн загвар

Компанийн фэйсбүүк хуудсанд лайк, шэйр хийх уралдаан зарлаж, азтаныг [www.woobox.com](http://www.woobox.com) сайтыг ашиглан шалгаруулж, азтанд “Би эндээс явахгүй” жүжгийн хос билетээр бэлэг барилаа. /Зураг 14/



Зураг 14. Уралдааны азтан

Хэвлэлийн үнэ болон дугааруудыг сар болгон тогтмол програм дээр оруулж, мэдээллийг шинэчлэн, сайт дээр байршуулж байсан ба фэйсбүүк хуудсаар дамжуулан, буухиа шуудангийн 24 төрөл, гадаад хэвлэл захиалгын 7 төрөл, дотоод хэвлэл захиалгын 9 төрөл, шуудангийн хайрцагны 15 нийт 57 төрлийн контент бэлтгэж сурталчилсан.

[www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) page хуудасны дагагчийн тоо 20,000, хандалтын тоо 700 гаруй мянгад хүрсэн. Энэхүү хандалтын 49% төлбөртэй, 51% органик хандалт байна.

Фэйсбүүк хуудсан дээр ТАБ хөгжүүлэлт хийж өгснөөр пэйж хуудсаар дамжуулан, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээ мэдээлэл авах хүмүүст улам дөхөм болгож, One Clock буюу нэг даралтаар хүссэн зүйлээ олж авах боломжтой болсон. Компанийн фэйсбүүк хуудасны мэдээ мэдээллийн төрлийг шинэчилж, шуудангийн үйлчилгээний сонирхолтой баримт, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байна.

Сошиал орчин хөгжсөн одоо үед “[mongolpost.mn](http://mongolpost.mn)” инстаграм хуудсыг энэ оны 03 сараас эхлэн хөтөлж, одоогийн байдлаар 15 төрлийн зурган мэдээ мэдээлэл оруулж хандалтыг авсаар байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглал, нийгмийн хариуцлагыг олон нийтэд сурталчлах чиглэлээр “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөгөөр шуудангийн үндсэн үйлчилгээ болон буухиа шуудан, гадаад паспорт, жолооны үнэмлэхний хүргэлтийн үйлчилгээний талаарх 3 төрлийн 4,000 ширхэг тараах материалыг павильон болон гаднах талбайд тараан сурталчиллаа.

Тус компани нь “Монголын эдийн засгийн чуулган-2018”-д оролцож, “Монголын эдийн засгийн чуулган-2018” цомыг гардан авлаа. Чуулганаар компанийн танилцуулга болон сурталчилгааны тарааж, сурталчилгаа хийлээ. /Зураг 15,16/





Зураг 15. Чуулганы тайзнаа



Зураг 16. Чуулганы үеэр ажиллаж буй нь

### 1.9. Үндсэн үйлчилгээг цахимжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар

Дэлхийн шуудан холбооны програмист Э.Борын дэмжлэгтэйгээр улс хоорондын шуудангийн чанар, мэдээлэл солилцоо, бүртгэл хяналтын IPS-2017 системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүллээ./Зураг 17/



Зураг 17. Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар Дэлхийн шуудан холбооны програмист Э.Борын хамт

Түүнчлэн кассын /POS/ системийг Улаанбаатар хот, аймгийн төвийн салбаруудад бүрэн нэвтрүүлсэн.

Шуудангийн уламжлалт үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнд чиглэсэн цахимжуулалт, техник технологүүдыг нэвтрүүлэх зорилгоор процессийн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Дотоод шуудан бүртгэлийн системийн тусламжтай гибрид шуудан үйлчилгээний хүрээнд “Скайтел” ХХК, “Юнител” групп, “Мобиком” корпорацийн авлагын мэдэгдэх хуудас хүргэх үйлчилгээ явагдаж байгаатай холбогдуулан, тэдний хүсэлт шаардлагын дагуу нэмэлт хөгжүүлэлтүүд хийгдэж байна.

Үүрэн холбооны 4 оператортай гэрээ хийж, “Хаан банк”-ны картын хүргэлтийг 151613 тусгай дугаараас хэрэглэгч рүү 2 шатанд мессеж илгээдэг болсон. Тухайлбал, Бичиг захидал ялган боловсруулах хэсэг хүлээн авсны дараа “Монгол шуудан хүлээлгэн өглөө”, гардуулах салбар хүлээн авсны дараа “Монгол шуудангийн \*\* салбар хүлээн авлаа” гэсэн мессеж хэрэглэгчид рүү илгээгддэг болсон ба масс мессеж илгээж байна. Өдөрт дунджаар “Мобиком”-оор 1834, “Юнител”-ээр 1745, “Скайтел”-аар 405, “Жи-мобайл”-аар 200, нийт 4200 орчим мессеж илгээсэн байна.

Аймгуудын ШҮГ-т “Шуудангийн борлуулалт удирдлагын систем” амжилттай нэвтрүүлж, үйл ажиллагааг жигдрүүлсэн ба асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Шуудан гардуулалтын гар утасны “гардуулалтын аппликешн” version 3.0-ийг хөгжүүлэн нэвтрүүлсэн ба офлайн горимд гардуулалт хийх, гар утаснаас гардуулах оролдлого хийх боломжтой болгосон.

Торгуулийн хуудас хүргэх үйлчилгээний хүрээнд дугтуйлагч машины тохиргоог хийж, бүх төрлөөр нь бүрэн ажиллагаанд оруулсан төдийгүй стандартын дугтуйг бэлэн болгосон. Өдөрт дунджаар 1000 ширхэг торгуулийн хуудас ирдэг ба дугтуйлахад 40 орчим минут зарцуулагдсанаар ажлын ачаалал ихээхэн хөнгөвчлөгдлөө.

Гадаад шуудан бүртгэлийн IPS2014 application client системийг IPS2017 application client, мөн IPS2014 web client системийг IPS2017 web client болгон шинэчилж, ачааллын алдааг зассан. Хятад – Монгол - Орос гэсэн транзит үйлчилгээнд зориулсан серверийг сайжруулж, IPS2017 web client-ийг шинэчлэн суурилуулснаар тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Транзит үйлчилгээний шаардлагаар улс хоорондын ITMATT мэдээлэл солилцох ажлын хүрээнд FTP сервер шинээр хийж, бүх тохиргоонуудыг хийж гүйцэтгэсэн, ITMATT мэдээллийг UPU дамжуулж авах шийдвэр гарсан тул UPU хамтран ажиллаж, ITMATT 9000 гаруй xml мэдээллийг дамжуулсан.

## ХОЁР. ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

### 2.1. Дотоод логистик үйлчилгээг өргөжүүлэх ажлын талаар

#### 2.1.1. Улаанбаатар хот доторх ачаа тээвэр

Замын-Үүд чиглэлийн ачаа эргэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор Улаанбаатар хот доторх хүргэлт, ачаа тээврийн хэмжээ тогтмол нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар логистикийн үйлчилгээнд Дүнжингарав салбарт 1, Орифлэйм ХХК-д 2 нийт 3 тээврийн хэрэгслийг бүрэн ажиллуулж байгаа ба III улиралд нэмж 1 машин логистикийн үйлчилгээнд оруулахаар судалж байна.

Шинээр “Орифлэйм Монгол” ХК, “Эм Импекс Концерн” ХХК-тай хамтран ажиллахаар урьдчилан тохиролцож, туршилтаар хотын дотор болон орон нутгийн хүргэлтийг эхлүүлээд байна. Энэхүү туршилтын хамтын ажиллагааны хүрээнд нийт 7,1 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд цаашид гэрээ байгуулан, албан ёсоор байнгын хамтын ажиллагааг хангаж ажиллахаар зорьж байна. /График 06/



График 06. Улаанбаатар хот доторх хүргэлт, ачаа тээврийн орлогын мэдээ /сая төг/

Улаанбаатар хот доторх хүргэлт, ачаа тээврийн эхний хагас жилд орлогын төлөвлөгөөг 18.1 сая төгрөг буюу 235 %-иар давуулан биелүүлсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,6 сая төгрөг буюу 332%-ийн өссөн үзүүлэлтийг хангаж ажилласан.

Орон нутгийн тээвэр эрхлэгч хувь хүмүүсийн судалгааг шинэчилж, нэг аймагт тогтмол тээвэр хийдэг 3-4 жолоочийг бүртгэж, нэгдсэн мэдээллийн бааз үүсгэсэн. Энэ ажлын хүрээнд хэрэглэгчдээс захиалга авч, гуравдагч буюу хувийн хэвшлийн тээвэр эрхлэгчээр тээвэрлүүлэх зуучийн үйл ажиллагааг амжилттай эхлүүлснээр Баян-Өлгий аймаг руу 1.5 тонн ачааг зуучилж, 300 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба цаашид энэхүү ажлыг идэвхжүүлэн, орлогоо нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

#### 2.1.2. Улаанбаатар-Дархан-Эрдэнэт-Булган логистикийн үйлчилгээ

Улаанбаатар–Дархан–Эрдэнэт-Булганы чиглэлийн логистик үйлчилгээг 2018 оны 06-р сарын 04-ний өдрөөс эхлүүлж, долоо хоногт 3 удаа тогтмол тээвэрлэх нөхцлийг хангаснаас гадна тухайн чиглэлийн шууданг давхар тээвэрлэж байна. /График 07/




График 07. Улаанбаатар-Дархан-Эрдэнэт-Булган чиглэлийн логистик үйлчилгээний орлогын мэдээ /төг/

Дээрх чиглэлд нийт 9 рэйс хийж, 1.991,7 сая төгрөгийн орлого хийсэн ба нийт зардалтай харьцуулахад 618,7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа боловч үйлчилгээг идэвхжүүлэх, сурталчлах ажлуудыг эрчимтэй хийж байна.

Орон нутгийн логистик үйлчилгээг идэвхжүүлэх, дэмжих зорилгоор аймгуудын ШҮГ ачаа олж ачуулсан тохиолдолд тухайн ачааны төлбөр тухайн аймгийн ШҮГ-ын орлого болж зардал нь компанийн зардалд тусах байдлаар тохиролцож, идэвхжүүлэлтийг хийх, Гүйцэтгэх захирлын гарын үсэгтэй хамтран ажиллах санал бэлтгэн тухайн чиглэл болон бусад чиглэлд тогтмол ачаа тээврийн үйлчилгээгээр хамтран ажиллах боломжтой гэж үзсэн 15 компаниудад илгээж, зарим компаниудтай нь очиж уулзах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Дотоод логистикийн үйлчилгээг хөгжүүлэх, өргөжүүлэхэд компанийн хүчин чадал хүрэлцэхгүй байгаа тул хувийн хэвшилтэй хамтран ажиллах талаар судалгаа хийж, ачаа тээврийн зуучийн үйлчилгээгээр эхлүүлэн ажиллаж байна.


Цаашид шинээр ашигтай тээврийн чиглэлийг нээж, тогтмол үйл ажиллагааг хангасны дараа хувийн хэвшлийнхэнд тухайн чиглэлийн тээврийг гэрээгээр өгч, хураамж авах байдлаар ашиг олох нөхцлүүдийг судалж байна. /Зураг 18/



Зураг 18. Сурталчилгааны брошюрын загвар

### 2.1.3. Автовокзалын тээшийн үйлчилгээ

АТҮТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд зүүн автовокзал буюу “Тэнгэр” худалдааны төв дотор тээшийн үйлчилгээний 2 дахь цэгийг байгуулсан. /Зураг 19/



Зураг 19. Зүүн автовокзалын тохижилт, засварын ажил

#### 2.1.4. Зүүн автовокзалын үйлчилгээ

Зүүн автовокзал нь зөвхөн 7 чиглэл рүү зорчигч тээврийн үйлчилгээг явуулдаг тул дайвар, тээшийн ачаа эргэлт баруун автовокзалтай харьцуулахад 5 дахин бага байдаг. Гэвч орлогыг нэмэгдүүлэх, зардал хэмнэх үйл ажиллагаануудыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. АТҮТ-ээс стикерэн баримтны бэлдэцийг хангуулахаар тохиролцсон ба ингэснээр зардал тодорхой хувиар хэмнэгдэж байгаа. Мөн ажилтнуудад ажлын гүйцэтгэлийг өдөр тутмын гүйцэтгэлээр нь үнэлэн, графикаар харуулж байхаар бүртгэлийг хийснээр 5 дугаар сараас эхлэн орлого 40%-аар нэмэгдсэн.

Цаашид буюу III улиралдаа багтааж, өдөр тутмын мөнгөн гүйлгээг санхүүгийн програмтай холбож, хэрэглэгчдэд е-баримт олгодог болгохоор төлөвлөж байна. /Хүснэгт 12/

Хугацаа	2018 он					
	Хадгалалт	Илгээлт	Нийт	АТҮТ	МШХК	Тээвэрлэгч
1 сар	3,435,000	769,200	4,204,200	1,832,880	1,832,880	538,440
2 сар	4,972,000	710,200	5,682,200	2,592,530	2,592,530	497,140
3 сар	3,928,000	1,182,000	5,110,000	2,141,300	2,141,300	827,400
4 сар	5,235,000	1,371,600	6,606,600	2,823,240	2,823,240	960,120
5 сар	6,863,000	917,300	7,780,300	3,569,095	3,569,095	642,110
6 сар	7,307,000	723,720	8,030,720	3,762,058	3,762,058	506,604
<b>НИЙТ</b>	<b>31,740,000</b>	<b>5,674,020</b>	<b>37,414,020</b>	<b>16,721,103</b>	<b>16,721,103</b>	<b>3,971,814</b>

Хүснэгт 12. Зүүн автовокзалын орлогын мэдээ

#### 2.1.5. Баруун автовокзалын үйлчилгээ

Баруун автовокзалын үйл ажиллагаа жигдэрч, сарын нийт үйл ажиллагааны орлого 8 саяд хүрч, компанид ногдох орлого 3,7 сая төгрөгт хүрсэн байна. /Хүснэгт 13/

Хугацаа	2018 он					
	Хадгалалт	Илгээлт	Нийт	АТҮТ	МШХК	Тээвэрлэгч
1 сар	3,435,000	769,200	4,204,200	1,832,880	1,832,880	538,440
2 сар	4,972,000	710,200	5,682,200	2,592,530	2,592,530	497,140
3 сар	3,928,000	1,182,000	5,110,000	2,141,300	2,141,300	827,400
4 сар	5,235,000	1,371,600	6,606,600	2,823,240	2,823,240	960,120
5 сар	6,863,000	917,300	7,780,300	3,569,095	3,569,095	642,110
6 сар	7,307,000	723,720	8,030,720	3,762,058	3,762,058	506,604
<b>НИЙТ</b>	<b>38,347,000</b>	<b>6,327,420</b>	<b>44,674,420</b>	<b>20,122,613</b>	<b>20,122,613</b>	<b>4,429,194</b>

Хүснэгт 13. Баруун автовокзалын орлогын мэдээ

Тээшийн илгээлтийг өөрийн шуудангийн хамт бэлтгэснээр тухайн төлбөр нь 100 хувь компанийн орлого болох тухай зааварчилгыг тогтмол өгч байгаа ба дээрх хүснэгтээс харахад тээвэрлэгчдэд олгох мөнгөн дүнгийн 40 орчим хувь нь компанийн орлого дээр нэмэгдэж байгаа болно.

Ирэх хагас жилээс эхэлж, 2 автовокзалын тээшийн үйлчилгээний цэг дээр ирсэн дайвар ачаа, тээшийг УБ хот дотор хүргэх үйлчилгээг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Тээшийн үйлчилгээний цэг дээр ажиллаж буй ажилтнуудын өдрийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өдөр тутмын ажлын үр дүнг тоон үзүүлэлтээр нь графикийн дагуу өдөр тутам дүгнэн, анализ хийхийн хажуугаар сануулга, зааварчилга өгч ажиллаж эхэлсэн. /График 08/




График 08. Тээшийн ажилтнуудын ажлын үзүүлэлт /өдөр тутам/

### 2.1.6. Улаанбаатар хот болон Замын-Үүдэд логистик терминалыг барих ажлыг судлах, зохион байгуулах:

Улаанбаатар хот болон Замын-Үүдэд логистик терминалыг барих боломжит газруудыг судалж байгаа ба УБ хотын зүүн хэсгээр илүү төвлөрөн хайж байна. Энэ талаар холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, төслөө танилцуулсан бөгөөд одоогоор энэ ажил зогсонги байдалтай байна.

### 2.2. **Улс хоорондын карго үйлчилгээг эхлүүлэх талаар**

Улс хоорондын илгээлт, карго үйлчилгээг эхлүүлэхэд шуудангийн илгээлт, EMS гэх мэт манай үндсэн үйлчилгээтэй шууд харшлах асуудлууд маш их гарах магадлалтай байгаа боловч төлөвлөгөөнд тусгасны дагуу судалгааг хийж байна. Урьдчилсан байдлаар БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй “Nice Mongolia World” компанитай хамтран ажиллах талаар ярилцаж байна. Тэдний ачааг зохих төлбөртэйгээр МИАТ карго терминал дээрээс

шууд Төв шуудан руу тээвэрлэн авчирч олголтыг хийх талаар урьдчилсан байдлаар судлахад Төв шуудангийн агуулахын багтаамж болон ачаалал нь хүрэлцэхгүй гэсэн урьдчилсан төлөв гарсан ч хамгийн их солилцоо ихтэй БНСУ руу чиглэсэн карго ачааг цуглуулан илгээж Солонгосын талын хамтрагчийг сонгон тараалгах боломжуудыг судалж байна.

Шинэ нисэх онгоцны буудал дээр олон улсын шуудан солилцооны терминал барих газар шийдэгдсэнтэй холбоотойгоор DHL-ын терминалын үйл ажиллагаа болон орлого, зарлагын судалгааг хийж удирдлагад танилцуулсан.

### 2.3. Гаалийн зуучлагчийн үйлчилгээ эхлүүлэх ажлын талаар

Гаалийн ерөнхий газраас зохион байгуулсан ГБМ-ийн сургалтанд 3 ажилтныг сургаж, сертификат, үнэмлэх гардуулсан. /Зураг 20/



Зураг 20. ГБМ-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үнэмлэх

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хууль, эрх зүйн талаас гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зөвшөөрөл авах, үйл ажиллагаа явуулах боломж үүссэн. ГЕГ-ын тусгай зөвшөөрөл олгох тухай шаардлага, нөхцлийн дагуу холбогдох материалуудыг бэлтгэн боловсруулж, нийт 69 хуудас бүхий тусгай зөвшөөрлийн хүсэлтийг ГЕГ-т 2018 оны 05-р сарын 05-ны өдөр хүргүүлсэн. ГЕГ-аас шинээр аж ахуй нэгжүүдэд гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг түр түдгэлзүүлсэн байгаа гэсэн хариу өгсөн байгаа.

Транзит шуудангийн үйлчилгээнээс гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулсны үр дүн эхний хагас жилд 46,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. /График 09/




График 09. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны орлогын мэдээ/сая төг/

Транзит шуудангийн үйлчилгээний гаалийн бүрдүүлэлтийн ажлыг хийж эхэлснээр шинээр орлогын эх үүсвэрийг бий болгосон ба 46,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 184 %-иар давуулан биелүүлсэн.

Мөн БНХАУ-ын тал Замын-Үүд боомтоор нэвтрэх автомашинуудад стандартыг мөрдүүлэх талаар хяналтыг нэмэгдүүлсний хүчинд ачааны эргэлт эрс багассан. Үүнтэй холбогдуулж, “Монгол Шуудан” ХК нь өөрийн тээврийн хэрэгслээр БНХАУ-ын Эрээн хотоос ачаа шууд тээвэрлэх талаар тооцоо судалгаа хийж байгаа ба тухайн барааны гаалийн бүрдүүлэлтийг хийхээр төлөвлөж байна.

#### **2.4. БНХАУ-ОХУ-ын хооронд хил дамнансан и-худалдааны логистик үйлчилгээг өргөжүүлэх ажлын талаар**

Тус компани нь 2018 эхний хагас жилийн транзитийн орлогыг 455,8 сая төгрөгөөр төлөвлөж, ачааллыг зөв, оновчтой зохион байгуулан ажилласны үр дүнд төлөвлөгөөг 410%-аар давуулан биелүүлж, 1,8 тэрбум төгрөгийг (1.8 тэрбум) төвлөрүүлж ажилласан. Энэ нь 2018 онд төлөвлөсөн нийт транзит шуудангийн орлогоос 20 хувиар давсан үзүүлэлт юм. /График 10/





График 10. Төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт /төг/

Транзит шуудангийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд тээвэр, гаалийн асуудлыг дотооддоо зохион байгуулж, нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгосон. Нийт тээвэрлэлтийн 90%-аас дээш хувийг автомашинаар гүйцэтгэсний сацуу шинээр төмөр замын тээвэр зуучийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, 2 удаа төмөр замаар транзит шуудан тээвэрлэлтийг амжилттай гүйцэтгэсэн./Зураг 21/



Зураг 21. ОХУ-ын шуудангийн төлөөлөгчийн хамт

Транзит шуудангийн 1,2 дугаар улирлын жингийн тулгалт /CN55, CN56/, тооцоо /CN61, CN64/-г сар, улирал бүр актаар баталгаажуулан тус тус тооцоо нийлсэн. Транзит шуудангийн буцаалт болон гаалийн хүндрэлтэй асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн ажилласан. SF express, East Solution 2 компанийн буцаалт Замын-Үүд боомтоор тогтмол



газраар ирж байгаа ба өөрийн дотоод логистикийн машинаар тээвэрлэж, гаалийн хяналтын агуулахад шууд хүлээлгэн өгч байна. 2018 оны 2 дугаар улирлын байдлаар хадгалалтын хугацаа нь хэтэрсэн нийт 338 богц буюу нийт 203554 ширхэг буюу 2863 кг шууданг гаальд хүлээлгэн өгч, устгалд оруулсан байна. Буцаалтыг гаалийн байгууллагатай ярилцаж зөвшилцсөний үр дүнд тусгай агуулахын зориулалттай 2 ширхэг контейнерийг компанийн автогаражид байрлуулсан.

БНХАУ-д 2018 оны 2 дугаар сард зохион байгуулагдсан “Улс хоорондын интернет худалдаанд гаалийн байгууллагын оролцоо, гаалийн хууль тогтоомжийг хөнгөвчлөх” олон улсын конференцид ГЕГ болон УХШИГГ-ын дарга нартай хамт оролцож, транзит шуудангийн үйл ажиллагааг хамтарч, тогтмол, хөнгөлөлттэй хийх тал дээр нэгдмэл байр суурийг бий болгосон.

ГИТ-Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн чиглэлийг БНХАУ-ын гүн рүү нэвтрэх боломжтой талаар нарийвчлан судалж, эхний байдлаар Эрээн хот руу нэвтрэх, ачаа ачих боломжийг нээж, гаалийн бүрдүүлэлтийг хэрхэн хийх болон процессын талаар судалгаа хийж эхлээд байна.

Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлд нийт 8100 орчим тонн ачаа бараа тээвэрлэж, 1,2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, орлого 620 %-иар өссөн үзүүлэлттэй ажиллаж байна. /График 11/



График 11. Замын Үүд-Улаанбаатар-Алтанбулаг логистик үйлчилгээний орлогын мэдээ/сая

Замын Үүд-Улаанбаатарын чиглэлийн түрээсийн тээврийн хэрэгслүүд дээр “МОНГОЛ ШУУДАН” ХК-ийн лого бүхий таних тэмдэг хэвлэж наан, хэрэглэгчдэд итгэл төрүүлснээс гадна тээврийн компаниудад хариуцлагыг өндөржүүлэх тал дээр заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Замын-Үүд-Улаанбаатарын чиглэлийн дотоод логистикийн тээврийн төлөвлөгөө 9.3%-ийн биелэлттэй гарсан нь 5-6 сард Замын Үүд боомт дахь гаалийн хорио, хязгаарлалтууд ихээр хийгдэж ачаа эргэлт багассантай холбоотой юм. Цаашид төлөвлөгөөний биелэлтийг нөхөж ажиллахын тулд тухайн чиглэлд өдөрт 2 тээврийн хэрэгсэл явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Транзит шуудангийн үйлчилгээг гүйцэтгэхдээ тээврийг хариуцан зохион байгуулж ажиллах нь дотоод логистикийн нийт орлого өсөх үндсэн гол шалтгаан болсон.

## ГУРАВ. САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭХЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

### 3.1. Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эхлүүлэх ажлын талаар

“Монгол шуудан” ХК нь EUROGIRO-той “Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эрхлэх” тухай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлэх чиглэлээр “Ард санхүүгийн нэгдэл” ХК-тай “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг 2018 оны 01 сарын 16-ны өдөр байгуулсан бөгөөд энэхүү үйлчилгээг эхлүүлэх технологи, үйл ажиллагааны бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. /Зураг 22/



Зураг 22. “Eurogiro”-той хамтран ажиллах гэрээ байгуулж буй нь

### 3.2. Даатгалын зуучийн үйлчилгээ үзүүлэх ажлын талаар

Тус компани нь даатгалын зуучийн мэргэжилтэн бэлтгэж, компанийн дүрмэнд даатгалын зуучийн үйлчилгээг эрхлэх нэмэлт өөрчлөлт оруулсан. Даатгалын зуучийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах, түүнтэй холбоотой материалыг бүрдүүлэн, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Central Tower-т “Ард санхүүгийн нэгдэл”-тэй хамтарч, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх жишиг салбар байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн.



## **ДӨРӨВ. ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

### **4.1. Шуудангийн солилцооны бүртгэл, судалгааны талаар**

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд **улс хоорондын шуудангийн** агаарын тээврээр 15596 ширхэг богц буюу 121454,0 кг, газраар 284 ширхэг богц буюу 2024,7 кг, **дотоодын шуудангийн** агаарын тээврээр 572 ширхэг богц буюу 3634,1 кг, төмөр замаар 4666 ширхэг богц буюу 18323,4 кг, өөрийн тээврээр 710 ширхэг богц буюу 5272,5 кг, Улаанбаатар хотын салбаруудад 32202 ширхэг богц буюу 185973,4 кг шуудан хүлээн авч, ялган боловсруулж гаргасан.

Илгээмж тус бүрээр задалбал, буухиа шуудан 109263 ширхэг, бичиг захидал 947554 ширхэг, илгээлт 23665 ширхэг, хэвлэл 2666589 ширхэгийг тус тус ялган боловсруулсан.

Шуудангийн саатлыг шалтгаан тус бүрээр нь ангилбал цаг агаарын саатлаас буухиа 195 ш, бичиг захидал 121 ш, тусгайбогц 4 ш, илгээлт 4 ш, хэвлэл 832 ш, дотоодын агаарын тээврийн компаниудын нислэгийн тоо цөөрсөн, зуны хэт их халуунаас шатахуун нөөцөлснөөснэг удаагийн нислэгт тээвэрлэх шуудангийн даац хэтэрсэн шалтгаанаар буухиа 1112 ш, бичиг захидал 495 ш, тусгай богц 26 ш, илгээлт 94 ш, хэвлэл 3177 ш, ажилтны буруугаас буухиа 1ш, бичиг захидал 11ш, хэвлэл 106 ш, тус бүр 1-2 хоног саатаж хүргэгдсэн ба үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 35.82%-иар өссөн байна. Сааталтай хүргэгдсэн шуудангийн илгээмжийн тоо хэмжээ нь нийт солилцооны 0.16%-ийг эзэлж байгаа бөгөөд бүх нийтийн үйлчилгээний чанарын саатлын үзүүлэлтийн зөвшөөрөгдсөн хэмжээнд байна.

### **4.2. Улс, хот хооронд, хотын доторх хүргэлтийн чиглэл, маршрутыг оновчтой зохион байгуулах, үр ашигтай болгох талаар**

Хотын доторх шуудан хүргэлтийн маршрутыг оновчлох асуудлыг ялган боловсруулах төвийг нүүлгэх ажилтай холбогдуулан түр хугацаагаар хойшлуулсан болно.

Улаанбаатар-Замын-Үүд чиглэлд өөрийн тээврийн давтамж цөөрсөн, галт тэрэгний цагийн хуваарьт өөрчлөлт орсонтой холбогдуулан, Улаанбаатар-Сайншанд-Улаанбаатар, Улаанбаатар-Замын-Үүд-Улаанбаатар чиглэлүүдийг нэгтгэн, нэг чиглэл болгосноор 2 удаагийн гарааг хэмнэсэн. Хэмнэсэн 2 гараагаа нэмэлтээр гаргаснаар зардлаа өсгөлгүйгээр шуудангийн давтамжийг Замын-Үүд суманд 2 удаа, Багахангай, Говьсүмбэр, Даланжаргалан, Айраг, Сайншанд чиглэлд тус бүр 1 удаагаар нэмэгдүүлж, дээрх чиглэлүүдэд шууданг 7 хоногт 4 удаа хүргэдэг боллоо.

Өөрийн тээвэр 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс Даваа, Лхагва, Баасан гарагт Улаанбаатар хотоос Дархан-Уул, Орхон аймгийн чиглэлд явж эхэлсэнтэй холбогдуулан хот хоорондын тээврээр явж байгаа зам дагуух сум, суурингийн шууданг шилжүүлсэн зохион байгуулж, 304 богцоор 2673.38 кг шуудан хүргэсэн ба ингэснээр шуудангийн илгээмжийн аюулгүй байдал, хяналтын хугацаа, хүргэлтийн чанар дээшилсэн.

Агаарын тээврийн компаниуд зуны нислэгийн хуваарьт шилжсэнтэй холбогдуулан улс хоорондын болон дотоод шуудан тээврийн хуваарийг шинэчлэн мөрдөн ажиллаж байна.

ОӨУБЕГ-ын гадаад паспортын хүргэлт, “Хаан банк”-ны “Приорити Алтан карт, Платинум Кредит карт”-ыг шуудангаар хүргүүлэх хүсэлтийн дагуу буухиа шуудангийн хүргэлтийн автомашиныг 2 автомашинаар нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангав. Ингэснээр шуудангийн илгээмжийг хүлээн авсан салбар дээр хонуулахгүйгээр ялган боловсруулах, дараагийн өдөр нь гардуулах салбар хүлээн авах боломж бүрдэнэ.

Орох солилцоо ихтэй, алслагдмал байрлалтай болон хүргэлтийн талбай ихтэй, шуудангийн үйлчилгээний 22, 32, 40, 42, 34, 30, 36, 37, 25, 49, 51 дүгээр салбаруудад

автомашинтай хүргэлт хийсэн ба эхний хагас жилийн байдлаар 7015 ширхэг илгээмжийг хаягт эзэнд нь гардуулсан байна. /Хүснэгт 14/

№	Төрөл	2018оны 1-р улирал			2018 оны 2-р улирал		
		Солилцоо /ш/	Гаалийн хяналтанд /ш/	Гардуулалт %	Солилцоо /ш/	Гаалийн хяналтанд /ш/	Гардуул алт%
1	Буухиа	6779	881	99.68	5530	759	92.94
2	Илгээлт	4028	757	93.09	3343	791	93.54
3	Бичиг захидал	6515	204	91.05	8486	180	90.15
<b>Нийт дүн</b>		<b>17322</b>	<b>1842</b>	<b>94.6</b>	<b>17359</b>	<b>1730</b>	<b>92.21</b>

Хүснэгт 14. Улс хоорондын болон дотоод шуудангийн гардуулалт

Улс хоорондын 34681 ширхэг шуудангийн илгээмж ирснээс 3572 ширхэг буюу 10.3% нь гаальд саатуулагдсан ба гардуулалт 93.4%-тай байна. Өмнөх улиралтай харьцуулахад улс хоорондын орох солилцоо 0.2%-иар өссөн боловч гардуулалт 2.39%-иар буурсан нь шинэ системд шилжсэн, мөн Postnet, IPS програмууд хоорондын мэдээлэл дамжуулалтанд алдаа гарч байсантай холбоотой байна.

Шуудангийн илгээмжийг гардуулсан даруйдаа системд мэдээлэл оруулахыг ШҮ-ний газар, салбаруудад шаардаж ажилласан ба шууданч, менежерүүдийн KPI-д тусгаж өгсөн нь үр дүнгээ өгч байна. Гар утсаар 289032 шуудангийн илгээмжийг гардуулсан нь нийт солилцооны 7.7%-ийг эзэлж байна.

Мөн илгээмжийн хүргэлт, гардуулалтын чанарыг сайжруулах зорилгоор улс хоорондын орох буухиа шуудан, илгээлтийн мэдээллийг бүртгэлийн системд хяналтын хугацаанд нь оруулаагүй ШҮ-ний газар, салбаруудын шууданч нарт Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу 508,3 мянган төгрөгийн торгууль ногдуулж ажилласан.

Шуудангийн солилцоо ихтэйгээс орон тоо нь хүрэлцэхгүй байгаа шуудангийн үйлчилгээний 36, 40, 42, 53-р салбарууд дээр орон тоо нэмэгдүүлэх, мөн шуудангийн үйлчилгээний 36-р салбараас 53-р салбарыг салган зохион байгуулах шаардлагатай байгаа тухай санал хүсэлтийг холбогдох газруудад оруулан шат дараатайгаар шийдвэрлүүлж байна.

#### 4.3. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдуулан, шуудангийн ашиглалт, технологийг оновчтой зохион байгуулах талаар

Шуудангийн үйлчилгээнд мөрдөгдөж байгаа журмуудыг шинэчлэх ажлын хүрээнд “Шуудангийн богцыг үйлдвэрлэх ба ашиглах журам”, “Монгол шуудан ХК-ийн газар, салбар, нэгж, хэсгүүдийн үйл ажиллагаанд гарсан технологийн зөрчил, саатал, гологдолд хариуцлага хүлээлгэх журам”-ыг тус тус шинэчлэн боловсрууллаа.

“Хаан банк”-ны харилцагчийн картыг шуудангаар хүргэх ажлын хүрээнд 169659 ширхэгийг хүлээн авч, 160931 (94.8%) ширхэгийг хаягт эзэнд хяналтын хугацаанд нь хүргэлээ. ЗХУТ-тэй хамтран ажиллах гэрээний хүрээнд 105198 ширхэг торгуулийн хуудсыг хүлээн авч, 81517 ширхэг (77.50%)-ийг гардуулсан ба хаяг нь тодорхойгүй, гардуулах боломжгүй 12644 ширхэг (12.02%)-ийг буцааж, 11037 ширхэг (10.5%)-ийн үлдэгдэлтэй байна. ОӨУБЕГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд гадаад паспорт 1945 ширхэг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ 93 ширхэгийг хаягийн дагуу хяналтын хугацаанд хүргэлээ. Гибрид шуудангийн үйлчилгээгээр Татварын Ерөнхий газар, дүүргүүдийн анхан шатны шүүх, “Скайтел” ХК, “Мобиком” корпораци, Юнител группээс с 63193 ширхэгийг хүлээн авч, ялган боловсруулсан ба 56850 ширхэг буюу нийт солилцооны 89.93%, хаягт эзэнд нь хүргэсэн.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах зорилгоор тус төвд шуудангийн нэг цэгийн үйлчилгээг бий болгосон бөгөөд одоогоор 1740 ширхэг илгээмжийг хүлээн авч хүргээд байна.

#### 4.4. Хэрэглэгчийн үйлчилгээг хариуцан, гомдол, хохирлыг барагдуулах талаар

Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв нь харилцах утсаар 18915, үйлчилгээний заалаар 845, УХШ-ийн лавлагаа 734, сайтны чатаар 984, дотоод сүлжээгээр 323, компанийн фэйсбүүк хуудсаар 317, электрон шуудангаар 15, бичгээр 126 лавлагаанд хариу өгч ажиллалаа.

“Хаан банк”-ны картын хүргэлттэй холбоотой гомдол, саналуудыг бүртгэн нэг бүрчлэн шалган нягталж байгаа ба гомдлын 50 орчим хувь нь банкны ажилтны өгсөн мэдээлэл буруу, “Хаан банк”-ны системийн алдаанаас шалтгаалсан, картын болон хавсралт гэрээний нэр хаяг зөрсөн, картын хаяг дээр буруу утасны дугаар бичигдсэнээс мессеж буруу хүнд очиж хэрэглэгчийг бухимдуулсан, өөрөө хүлээн авахаар хаягласнаас салбар хиймэл ачаалал үүсгэж, хэрэглэгчийг бухимдуулсан, мөн байгаа газарт нь хүргэж өгөх ёстой гээд байршлаа солиод заавал одоо хүргүүлнэ гэсэн банкны ажилтны өгсөн буруу мэдээллээс үүдсэн гомдлууд байна. Шууданчийн зан харьцааны талаар гарсан гомдол болон ажлын бус цагаар хүргүүлэх гэсэн хүсэлтийг шууданч нартайгаа ярилцан шийдвэрлэж байна. /График 12/




График 12. Лавлагааны сурвалж

Хэрэглэгчийн гомдол, саналд тухай бүр нь дүгнэлт хийж, уг ажлын мөрөөр арга хэмжээ авч, үйлчилгээг сайжруулан ажиллаж байна./График 13/



График 13. Хэрэглэгчийн асуулга

#### **4.5. Хаягийн стандарт мөрдүүлэх, зип кодын хэрэглээг нэмэгдүүлэх талаар**

Хаягийн стандарт мөрдүүлэх, зип кодын хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ялган боловсруулах хэсгүүдийн орох шуудангийн илгээмжинд шалгалт хийхэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Орхон аймгийн ШҮГ, төвийн салбар, 26, 38, 44-р салбаруудад заавар, зөвлөмж өгч ажилласан ба үүнээс Говьсүмбэр, 26-р салбарын орох шуудангийн илгээмжийг буцааж, саатлыг тухай ажилтнуудад тооцсон болно.

Мөн ХХЗХ-ноос төрийн албан байгууллагуудад шат дараатайгаар хаягийн стандарт, зип кодын хэрэглээний талаар сургалт хийхээр төлөвлөж байгаа ба мөн Монгол шуудангаас хаягийн стандарт мөрдөхгүй байгаа албан байгууллагуудын жагсаалтыг гаргаж, хамтран ажиллахыг дэмжих албан хүсэлтийн хамт ХХЗХ-нд хүргүүлээд байна.

Илгээмжийн хаяг тодорхойгүй шуудангийн илгээмжийг гардуулах оролдлого хийхийн тулд Нийслэлийн иргэний бүртгэлийн газраас оршин суух хаягийг тодруулан 4 иргэнд, фэйсбүүк болон и-мэйлээр 136 иргэнд хаягаар нь мэдэгдэж, нийт 54 ширхэг шуудангийн илгээмжийг гардуулав. Түүнээс гадна нийслэлийн зарим зуслангийн газар, алслагдсан хороодод хаягжилт байхгүй, мөн хороон дээр нь хаягийн бүртгэл байхгүй байгаа нь шуудангийн илгээмжийг хүргэхэд хүндрэл учруулж байна.

Хүлээн авагчийн хаягийг тодорхойлох боломжгүй 8701 ширхэг шуудангийн илгээмжийг илгээгч улс руу буцаасан, очих болон буцах хаяг тодорхойгүй 96 ширхэг шуудангийн илгээмжийг журмын дагуу устгалын комисст шилжүүлэн шийдвэрлэлээ.

#### **4.6. Технологийн зөрчил, саатлын талаар**

Технологийн 49 зөрчил гарсан ба ажилтнуудын хайхрамжгүй байдал, шуудангийн технологийн мэдлэг дутмагаас шалтгаалсан байна.

Баян-Өлгий аймгийн ШҮГ-ын шууданч н.Батухан нь 2018 оны 2-р сард ОБЕГ-аас тус аймгийн ОБГ-т илгээсэн албан бичгийг итгэмжилсэн албан тушаалтанд гардуулалгүй өөр хүнд гардуулсан.

40-р салбарын шууданч Д.Эрдэнээ нь 3 ширхэг бүртгэгдсэн албан бичиг, 49-р салбарын үйлчилгээний ажилтан Т.Адъяа нь БНХАУ-аас орох бүртгэлтэй боодлыг алдаж үрэгдүүлсэн, мөн ОХУ-аас ирсэн бүртгэлтэй боодлыг хүлээн авагч ажлын байрнаас аваад явсаныг мэдээгүй зэрэг ноцтой зөрчлүүд гарсан дээр дүгнэлт хийн ажиллагсдыг ажлын байран дээр сэлгүүлэн ажиллуулах, ажлын байрны дотоод хяналт шалгалтыг хуваарийн дагуу хийх, ажил тарсаны дараа болон амралтын өдрүүдэд тогтмол хяналт тавих зэргээр арга хэмжээ авч ажиллалаа.

Үйлчилгээний ажилтнууд шуудангийн илгээмжийн мэдээллийг системд бүртгэхдээ чиглэл, жин, төрөл зэргийг буруу оруулдаг зөрчил арилахгүй байна.

“Хаан банк”-ны картын хүргэлтийн үйл ажиллагаанд онцгой анхааран ажилласнаар банкны картыг өөр хүнд гардуулах зөрчил бүрэн арилсан. Гэвч солилцооны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хяналтын хугацаанаас хоцроож гардуулах, хяналтын хугацаанд гардуулагдаагүй картыг банкинд буцаан хүргэх ажлыг хугацаанаас хоцроох зэрэг зөрчлүүд байсаар байна. Эдгээр зөрчлүүдийг арилгахын тулд “Хаан банк” болон чанарын удирдлагын албатай хамтран, сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дээрх зөрчлүүд нь шууданчдын хайхрамжгүй байдал, технологийн болон програмын мэдлэг дутуу, ажлын ачаалал их, шинэ ажилтнуудын дадлага туршлага дутмаг байгаа зэргээс шалтгаалан гарч байна.

## ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

### 5.1. Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар

#### 5.1.1. Хүний нөөцийн мэдээлэл

Өнөөдрийн байдлаар компанийн хэмжээнд шуудангийн үйлчилгээний 39 салбар, 22 аймаг, дүүргийн газар, 331 сумын салбарт нийт 924 хүн ажиллаж байна. 2013 оныг суурь болгон авч үзвэл, ажиллах хүч 69-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ажиллах хүчний өсөлтөд торгуулийн хуудас, банкны карт, жолооны үнэмлэхний хүргэлт, ачаа тээвэр, логистикийн үйлчилгээ голлох нөлөөллийг үзүүлж байна. /График 14/



График 14. Нийт ажилтнуудын тоо

“Монгол шуудан” ХК нь бүх нийтийн үйлчилгээний үүргийг хүлээдэг компанийн хувьд Монгол Улсын бүхий л сум суурийн газруудад салбар нэгж ажиллуулдаг ба компанийн нийт ажиллах хүчний 43,7% буюу 404 нь Улаанбаатар хотод, 56,3% буюу 520 нь аймгийн шуудангийн үйлчилгээний газарт ажиллаж байна. Үүнээс үндсэн 836, гэрээт 37, түр 51 ажилтан байна. /График 15/



График 15. Ажилтнуудын байршил

Хүйсийн хувьд авч үзвэл, 72 хувь нь эмэгтэй, 28 хувь нь эрэгтэй ажилтан байна. Энэ нь 2013 онтой харьцуулбал нийт ажилтанд ногдох эрэгтэй ажилтны хувийн жин 1.6%-иар буурсан байна. /График 16/



График 16. Ажилтнуудын хүйсийн харьцуулалт

Тайлант хугацаанд 3% нь 24 хүртэлх, 17% нь 25-29 хүртэлх, 16% нь 30-34 хүртэлх, 12% нь 35-39 хүртэлх, 12% нь 40-44 хүртэлх, 18% нь 45-49 хүртэлх, 15% нь 50-54 хүртэлх 7% нь 55 ба түүнээс дээш насны ажилтан байна. /График 17/




График 17. Ажилтнуудын насны ангилал

Компанийн ажилтнуудын дундаж насыг сүүлийн 6 жилийн байдлаар харахад, 2014 онд 42 байсан бол 2018 онд 39 болсон байна. /График 18/




График 18. Ажилтнуудын дундаж нас

### 5.1.2. Ажилтны тогтвор суурьшил

Ажилтнуудын тогтвор суурьшлыг 2018 оны эхний хагас жилийн байдлаар үзэхэд, нийт 30 ажилтан буюу 3,2% нь ажлаас чөлөөлөгдсөн ба шалтгааны хувийн жинг нийт ажилтны тоотой харьцуулахад өөрийн хүсэлтээр 24 ажилтан буюу 2.5 хувь, захиргааны санаачилгаар 6 ажилтан буюу 0,65 хувийн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд ажилд 38 хүн шинээр ажилд орж, энэ нь нийт ажилтны 4.1 хувийг эзэлж байна. 2018 оны эхний хагас жилд нийт ажилтны 30 хүн тутмын 1 нь ажлаас чөлөөлөгдөж, мөн тооны хүн ажилд орсон бөгөөд 8 орон тоо шинээр нэмэгдсэн байна.

Шинээр ажилд орсон ажилтнуудын мэдээллийг спаркаар зарлаж, газар, хэлтэс, албадад танилцуулж эхэлсэн.

### 5.1.3. Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ байгуулах

Тус компани нь удирдлага, зохион байгуулалт, хөдөлмөрийг оновчтой хуваарилан, орон тоог төлөвлөж, компанийн удирдлагын бүтцийг 2018 оны 01 дүгээр сарын 02-ноос эхлэн, шинэчлэн зохион байгууллаа.

Ажилтнуудын ажил үүргийг оновчтой хуваарилах, ажлын хариуцлагыг тодорхой болгох үүднээс ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн ажиллалаа. Зарим нэгэн орон тооны нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан, газар, хэлтэс, албадын чиг үүргийг удирдлагуудад танилцуулан, түүнтэй уялдуулан, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгууллаа.



#### **5.1.4. Сонгон шалгаруулалт**

Давхардсан тоогоор 18 ажлын байрыг сонгон шалгаруулах журмын дагуу нээлттэй зарлан, 453 ажил горилогчийн материал хүлээн авснаас 5 ажлын байранд ажилтныг сонгон шалгаруулж авсан.

#### **5.1.5. Хүний нөөцийн судалгаа, мэдээлэл гаргах**

Харилцаа, холбооны зохицуулах хороо, Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Чингэлтэй дүүрэг, ШУТИС, МУИС-иас ирсэн хүний нөөцтэй холбогдолтой судалгаануудыг хугацаанд нь бөглөн явуулснаас гадна Авилгатай тэмцэх газраас “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 оны 03 дугаар сараас 2 сарын хугацаатай шалгалт хийхэд хүний нөөцтэй холбогдолтой мэдээллээр бүрэн хангаж ажиллалаа.

#### **5.1.6. Шагнал урамшуулал**

Харилцаа, холбоо, мэдээллийн технологи үүсч хөгжсөний 97 жилийн ойг тохиолдуулан, төрийн одон медалиар 24, “Хүндэт холбоочин” цол тэмдгээр 5, “Шуудангийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр 14, Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1, “Хүндэт жуух” 12, Сангийн Яамны шагналаар 3, компанийн өргөмжлөлөөр 23 ажилтанг тус тус шагнуулахаар ажил байдлын тодорхойлолт болон бусад холбогдох материалуудыг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлээд байна.

#### **5.1.7. Ээлжийн амралт, түүнд тавих хяналт**

2018 оны ээлжийн амралтын хуваарийг ажилтнуудын санал, ажлын ачаалал, шаардлагад нийцүүлэн хийж, Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/07 тоот тушаалаар батлуулан, ээлжийн амралтын мэдэгдлийг гарган, ээлжийн амралт авах ажилтан бүрт хүргүүлэн ажиллалаа.

#### **5.1.8. Хүний нөөцийн програмын хөгжүүлэлт**

Хүний нөөцийн програмын нэгдсэн тайлан гаргах, харьцуулалт, хайлт хийхэд хүндрэлтэй, мэдээллийн найдвартай хадгалалт сул байсныг тодорхой хэмжээнд шийдвэрлэж, хөгжүүлэлт хийн ажиллаж байна.

### **5.2. Архив, албан хэрэг хөтлөлт, ирсэн бичгийн хяналтын талаар**

#### **5.2.1. Ирсэн бичиг, түүнд тавих хяналт**

Компанийн хэмжээнд нийт 807 ширхэг албан бичиг ирснээс хариутай бичиг 142, энгийн бичиг 665 байна. Хариутай бичгийн хувьд авч үзвэл, Захиргаа, хүний нөөцийн газарт 55, Бизнес хөгжлийн газарт 25, Шуудангийн технологийн газарт 25, Стратеги, төлөвлөлтийн газарт 13, Тээвэр зууч, логистикийн газарт 8, Мэдээллийн технологийн газарт 3, Нягтлан бодох бүртгэлийн хэлтэст 8, Аж ахуй, үйлчилгээний албанд 2, Марк, үнэт цаасны хэлтэст 3 албан бичиг тус тус бүртгэгдсэн байна. Хугацаандаа шийдвэрлэгдсэн 121, шийдвэрлэх шатандаа байгаа 8, хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдээгүй 13 албан бичиг байна./График 19/




График 19.Хариутай бичгийн шийдвэрлэлт

### 5.2.2. Явуулсан бичиг

Компаниас явуулах бичгийг хүлээн авч бүрдэл, хавсралт, хаягийн зөв эсэхийг шалган, тамга тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлан хаяглах, хаягт эзэнд нь явуулах ажлуудыг журмын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 410 ширхэг албан бичгийг дугаарлан бүртгэж явуулсан байна.

### 5.2.3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Захиргаа, хүний нөөцийн газарт нийт 87 өргөдөл ирснээс 71 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, орон сууцны дэмжлэг хүссэн 16 өргөдөл хүлээгдэж байна. /График 20/



График 20. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт

#### 5.2.4. Архивын нэгж

Хадгаламжийн санд 2018 онд батлагдсан “Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт”-ын дагуу өмнөх оны нийт 253 ширхэг баримт бичгийг хүлээн авсан. Хадгалах хугацаа нь дууссан 198 баримтыг цаасны үйлдвэрт устгал хийлгэлээ.

Архивын материалаас 1984-1990, 1997-2005, 1998-2000 оны хоорондох цалин, нийгмийн даатгал шимтгэлийн материал зэргийг баримт материалыг хайж, лавлагаа гарган өгсөн.

Мөн 141 ширхэг тушаал, 80 ширхэг ирсэн бичгийг скайнердаж, цахим архивт бэлтгэж ажилласан.

### **5.3. Дотоод ажлын талаар**

#### 5.3.1. Тушаалын төсөл боловсруулж батлуулах, тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар

Тайлангийн хугацаанд компанийн гол үйл ажиллагаатай холбогдолтой 121 “А” тушаал, хүний нөөцтэй холбогдолтой 148 “Б” тушаалын төсөл боловсруулж батлуулсан байна.

Гүйцэтгэх захирлын “А” тушаалаар 28 үүрэг даалгавар өгснөөс 70%-ийн биелэлттэй, “Б” тушаалаар 15 даалгавар өгснөөс 100%-ийн биелэлттэй байна. /Хүснэгт 15/

№	Нэгжийн нэр	А тушаал		Б тушаал		Тайлбар
		Ү/Д-ын тоо	Хувь	Ү/Д-ын тоо	Хувь	
1.	Захиргаа, удирдлагын газар	9	100%	12	100%	
2.	Бизнес хөгжлийн газар	4	90%	-	-	Хэрэгжүүлж байгаа
3.	Стратеги, төлөвлөлтийн газар	4	60%	-	-	Хэрэгжүүлж байгаа
4.	Тээвэр зууч, логистикийн газар	1	100%	-	-	
5.	Шуудангийн технологийн газар	3	90%	1	100%	Хэрэгжүүлж байгаа
6.	Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	2	100%	2	100%	
7.	Дотоод аудитын хэлтэс	1	0%	-	-	Ажил эхлээгүй
8.	Хөрөнгийн удирдлагын хэлтэс	1	0%	-	-	8 сар хүртэл хойшлогдсон
9.	Чанарын удирдлагын алба	1	80%	-	-	Хэрэгжүүлж байгаа
10.	Аж ахуй, үйлчилгээний алба	2	80%	-	-	Хэрэгжүүлж байгаа
	<b>Нийт</b>	<b>28</b>	<b>70%</b>	<b>15</b>	<b>100%</b>	

*Хүснэгт 15. Тушаалын хэрэгжилт /газар, хэлтэс, алба/*

#### 5.3.2. Тайлан, төлөвлөгөө боловсруулж батлуулах, түүний биелэлтийг хангуулах

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, удирдах дээд байгууллагуудад хүргүүлсэн ба компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Захиргаа, хүний нөөцийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн явцад тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг улирал бүр дүгнэн, биелэлтийг хангуулж ажиллууллаа. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндсэн 12 чиглэлээр, нийт 356 ажил төлөвлөснөөс эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт 53,34%-тай байна. Хугацаа болоогүй 32,3%, хийгдээгүй ажлуудын 7,68% нь дутуу хийгдсэн, 6,7% нь хугацаандаа огт хийгдээгүй ажлууд байна. Дутуу буюу огт хийгдээгүй ажлуудын шалтгаан нь ажил төлөвлөсөн ч суурь нь огт тавигдаагүй, мөнгө санхүүтэй холбоотой, тендер зарлаагүй, ажилтны тогтвор суурьшилгүй байдал, хэт ачаалалтай ажил төлөвлөсөн зэргээс шалтгаалжээ. /График 21/




График 21 Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөгөөний биелэлтийн хувийг газар, хэлтэс, албаар нь ангилж харуулбал:




График 22.Төлөвлөгөөний биелэлт /газар, хэлтэс, алба/

### 5.3.3. Цаг ашиглалт

Компанийн ёс зүйн хэмжээг сахиж, цаг ашиглалтад 7 хоног бүр тогтмол хяналт тавин ажиллаж, хоцролт, чөлөөний мэдээг компанийн дотоод сайтад байршуулан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан, удаа дараа хоцорсон, ажлын цагийг хийдүүлсэн зарим ажилтнуудад сахилгын арга хэмжээ авч ажиллалаа. /График 23/




График 23.Ажлын цаг ашиглалт

Дээрх зургаас харахад, цаг бүртгэлийн хурууны хээ унших төхөөрөмжөөр цагаа бүртгүүлдэг 308 ажилтнуудын хувьд, 2018 оны 1-5 сард нийт 261184 цаг ажиллахаас 255777,3 цаг ажилласан байна. Үүнээс 121,7 цагийн хоцролттой, 2221,2 цагийн чөлөөтэй, 3063,8 цагийн өвчтэй байсан ба 1 хүнд ногдох цагийн гарздал 16.85 цаг байна.

#### **5.4. Нийгмийн асуудлын талаар**

##### **5.4.1. Цалин хөлс, урамшилт цалин**

“Монгол шуудан” ХК, шуудангийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2017-2018 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд 2017 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэн, Улаанбаатар хотын ажилтнуудын цалинг 2018 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс, аймгийн ШҮГ-ын ажилтнуудын цалинг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус бүр 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Нийт ажилтнуудын дундаж цалинг сүүлийн 2 жилээр харьцуулахад, Улаанбаатар хотын ажилтнуудын дундаж цалин 2017 онд 746,5 мянган төгрөг байсан бол 2018 онд 877,7 мянган төгрөг болж, 1,18 хувиар, аймгийн ШҮГ-ын ажилтнуудын дундаж цалин 2017 онд 326,9 мянган төгрөг байсан бол 2018 онд 346,3 мянган төгрөг болж, 1,06 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Ажлын үр дүнгээр олгодог урамшилт цалинг компанийн бизнесийн гүйцэтгэлд оруулсан үндсэн ажилтнуудын хувь нэмрийг ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр дүгнэж урамшуулах “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ”-ний шинэ систем KPI-аар Хамтын гэрээнд заасан хугацаанд тогтмол олгож ирсэн.

##### **5.4.2. Буцалтгүй тусламж, тэтгэмж, дэмжлэг, хөнгөлөлт**

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-г өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь хагацал тохиолдсон 1 ажилтанд 100,0 мянган төгрөгийн, ойр дотных нь хүн нас барсан 8 ажилтанд 1,200.0 мянган төгрөгийн тэтгэмж, ар гэр нь болон өөрөө хүндээр өвдсөн 2 ажилтанд 300.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээ.

Өрх толгойлсон 32 ажилтанд 1,920.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний, сувилалд сувилуулсан 8 хүнд 320.0 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт үзүүлсэн.

#### **5.5. Зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар**

##### **5.5.1. Спортын арга хэмжээ**

“Монгол Шуудан” ХК нь ажилтнуудынхаа бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх зорилгоор компанийн болон харилцаа холбооны салбарын 2018 оны аварга шалгаруулах спортын 4 төрөлт уламжлалт тэмцээнийг 2018 оны 04, 05 сард амжилттай зохион байгуулж, багаараа гуравдугаар байр эзэллээ. /Зураг 23/



Зураг 23. Салбарын спортын аварга шалгаруулах тэмцээний

## 5.5.2. Хурал, зөвлөлгөөн

### А. ОРОН НУТГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨЛГӨӨН

“Монгол шуудан” ХК-ийн “Орон нутгийн удирдах ажилтны зөвлөлгөөн-2018” Улаанбаатар хотын “Наранбулаг” зочид буудалд 2018 оны 02 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Уг арга хэмжээ нь аймгуудын ШҮГ-ын удирдлагуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, харилцан туршлага солилцуулсанаар тэдэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх тухай арга замыг хайж олоход туслалцаа үзүүлж чадсан үр дүнтэй ажил боллоо. /Зураг 24/



Зураг 24.Орон нутгийн удирдах ажилтны зөвлөлгөөн

### Б. НЭГ ЗОРИЛГО-НЭГ БАГ” СЭДЭВТ ХУРАЛ

“Монгол шуудан” ХК нь нэгэн зорилгод нэгдсэний бэлгэдэл бүтээх болон компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс болон үйл ажиллагааны шинэчлэлийг Улаанбаатар хотын ажилтнуудад таниулан сурталчлах зорилгоор “НЭГ ЗОРИЛГО-НЭГ БАГ” сэдэвт хурлыг 2018 оны 05 сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Хуралд нийт 288 ажилтнууд оролцсон. /Зураг 27/



Зураг 25.Нэг зорилго-нэг баг хурлын үеэр

Хурлын үеэр “Компанийн бодлого шинэчлэл”, Компанийн эрхэм зорилго, хэтийн зорилго, үнэт зүйлс”, “Хувь хүний хөгжил, эерэг сэтгэлгээ”, “Бүтээмжийн талаарх ойлголт, танилцуулга” сэдэвт танилцуулга, сургалтуудыг зохион байгуулж, 5С-аудиторуудын багийн гишүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар үүсч хөгжсөний 97 жилийн ойн нэрэмжит спортын арга хэмжээнд амжилттай оролцсон тамирчдыг алдаршууллаа.

## **В. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

“Монгол Шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа. /Зураг 26/



*Зураг 26. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр*

Хурлаар Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулсан ба компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсөв, компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар авч хэлэлцэн, баталлаа.

### **5.6. Сургалт, хөгжлийн талаар**

#### **5.6.1. Дотоод сургалт**

Сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр сургалтын төлөвлөгөө боловсруулж, ажилтнуудыг танхимын болон ажлын байран дээрх сургалтанд сургаж, мэргэшүүлэх, давтан сургах, шинээр томилогдсон ажилтнуудад мэргэжлийн чиг баримжаа олгох зэргээр зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч хариуцсан мэргэжилтний тогтвор суурьшилгүй байдлаас болж, сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж чадсангүй.

Шинээр ажилд орсон хүмүүст ажлын чиг баримжаа олгох зорилгоор шинэ ажилтны сургалтыг “Шуудангийн технологи, шат дамжлага”, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа” “Компанийн тухай танилцуулга”, “Маркийн тухай ерөнхий ойлголт”, “Харилцааны соёл” зэрэг сэдвийн хүрээнд 306 тоот өрөөнд зохион байгууллаа.

Аймгийн ШҮГ-ын ажилтнуудын ажлын байран дээр нь сургаж мэргэшүүлэх, тэдний үйлчилгээний харилцаа, соёлыг дээшлүүлэх зорилгоор Дархан-Уул, Орхон, Дорноговь аймгийн ШҮГ-ын ажилтнуудад сургалт зохион байгууллаа. /Зураг 27/



*Зураг 27.Орон нутгийн сургалт*

### **5.6.2. Гадаад сургалт**

Тайлант хугацаанд Тайланд Улсын Ази номхон далайн болон дэлхийн шуудангийн байгууллагын ажилтнуудын сургалтын төвд “Шуудангийн аюулгүй байдал” “Цахим худалдаанд шуудангийн байгууллагуудын бэлэн байдал, чанарын сангийн төсөл бичих” зэрэг сэдэвт сургалтад холбогдох албан тушаалтнуудыг хамрууллаа. /Зураг 28/



*Зураг 28.Гадаад сургалт*

## **5.7. Ахмад настны талаар**

### **5.7.1. Тэтгэмж буцалтгүй тусламж**

МШХТГ-ын даргын “Ахмад настны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 04-р сарын 13-ны өдрийн 1/210 тоот зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, компанийн ахмад настнууд, ажиллаж байгаа болон өндөр насны тэтгэвэрт гарсан “Хүндэт холбоочин”-д 4.745.0 мянган төгрөгийн нэмэгдэл тэтгэмжийг олгосон ба компанийн ахмад настнуудын биеийн байдал, ахуй амьдралын асуудлаар холбогдох хүмүүсээс байнга мэдээлэл авч, хүнд өвчнөөр өвдөж, хүний асаргаанд орсон 6 ахмадыг эргэж, 600.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан 7 ахмад настанд 700.0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо.

### **5.7.2. Хүлээн авалт**

“Монгол Шуудан” ХК-ийн зүгээс шуудан, харилцаа, холбооны салбарт оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж байсан үе үеийн ахмадуудаа Билгийн тооллын ХҮИ жарны “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилийн жилийн сар шинийн баярыг тохиолдуулан хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, 7.9 сая төгрөгийг зарцуулжээ./Зураг 29/





*Зураг 29. Ахмад настныг хүлээж авсан нь*

### **5.7.3. Спортын арга хэмжээ**

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хэмжээнд ахмадын шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, уг тэмцээнд амжилттай оролцож, 1 алт, 1 мөнгөн медаль авлаа. /Зураг 30/



*Зураг 30. Ахмад настны шатрын тэмцээний аваргууд*

## **5.8. Чанарын удирдлагын талаар**

### **5.8.1. Бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааны тасралтгүй сайжруулалт**

Компанийн нийт ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн чанар-бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах 5С-ийн тооцоо судалгааг хийж, журмын төслийг боловсруулсан. Уг судалгааны хүрээнд дотоодын байгууллагуудаас “Таван богд” группын охин компани болох “Улаанбаатар принт” хэвлэх үйлдвэр, “Скайтел” групп, “Шунхлай” группын туршлагаас судаллаа.

5С-ийн хэрэгжүүлэлтийн бэлтгэл ажлыг хангах, тухайлбал, 5С-ийн стандарт, үнэлгээний хуудсыг боловсруулах, цаашид стандартын дагуу 5С хэрэгжсэн ажлын байруудад сар бүр тогтмол аудит хийх зорилгоор газар, алба, хэлтсүүдийн төлөөллийг оролцуулсан 5С-ийн аудитуудын багийг байгуулж 5С-ийн оффисын ажлын байрны стандартыг боловсруулсан бөгөөд бусад ажлын байрны стандартууд боловсруулалтын шатанд хийгдэж байна. /Зураг 31, 32/



Зураг 31. 5С-ийн аудиторын баг



Зураг 32. 5С-ийн аудиторын багийн

Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулах, ажилтны идэвх оролцоог хангах ажлын хүрээнд Employee suggestion scheme буюу Кайзен саналын системийг нэвтрүүлэх тооцоо судалгааг хийж, журмын төслийг боловсруулан ажиллалаа.

Нэгж ажилтны хувь хүний хөгжил-манлайлал, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор чанарын дугуйлангийн үйл ажиллагааг нэвтрүүлэх тооцоо судалгааг хийж ажиллалаа.

### 5.8.2. Мэдээлэл, сургалт, чанарын соёлын төлөвшилт

Хэрэглэгч төвтэй байгууллагын соёлыг төлөвшүүлэх, үйлчилгээний соёлыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын ШҮ-ний салбаруудын 130 гаруй үйлчилгээний ажилтан, шууданч, шууданч-жолооч нарт “Харилцаа-үйлчилгээний стандарт”-ын сургалтыг зохион байгууллаа. /Зураг 39/

Хэрэглэгчийн хүсэл шаардлагад нийцсэн соёлтой үйлчилгээг үзүүлэх “Эерэг хандлага, харилцааны урлаг”, “Ажлын байр-аз жаргал, бахархал болох нь” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын шууданчдад зохион байгууллаа. /Зураг 33/



Зураг 33. Харилцаа үйлчилгээ стандартын сургалт

### 5.8.3. Чанарын удирдлагын хяналт, баталгаажуулалтын талаар

ХҮЛТ-ийн операторуудыг өдөр тутмын удирдлагаар хангаж, гадаад гарах шуудангийн /буухиа, илгээлт, бичиг захидал/ хяналтын хугацаа, саатал, хэрэглэгчийн гомдол санал зэрэгт хяналт тавьж ажиллалаа. Энэ хугацаанд лавлагааны чанарын үзүүлэлтийг 2018 оны I улирлыг өмнөх оны III улирлын үзүүлэлттэй харьцуулахад, 6.44%-иар буюу 97.62% өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 16, 17/



Global Customer Service System © IPC

## EMS Customer Service Performance Consolidated Report

			As replying partner									
			Customer service response quality		Timeliness				Quality			
			On-time reply (0.5) 1 Level Resolution (0.25)		On-time reply (EMS reply time standards)		Time to open requests received		Workflow Resolution		Workflow Duration (< 15 working days)	
IS	Country name	Region	%	#	%	working hours	#	%	%	working days	%	
ML	Mali	Africa	69,45	15	66,67	7:16:48	9	44,44	11,11	2,41	100,00	
MM	Myanmar	Asia Pacific	91,83	25	88,00	4:53:48	23	91,30	0,00	0,85	100,00	
<b>MM</b>	<b>Mongolia</b>	<b>Asia Pacific</b>	<b>91,18</b>	<b>21</b>	<b>100,00</b>	<b>0:10:55</b>	<b>17</b>	<b>76,47</b>	<b>11,76</b>	<b>5,57</b>	<b>88,24</b>	
MO	Macao (China)	Asia Pacific	95,90	69	100,00	0:24:45	61	86,89	0,00	2,18	96,72	
MR	Mauritania	Arab	85,00	10	100,00	1:17:02	5	40,00	20,00	5,64	100,00	
MT	Malta	Europe	88,24	64	98,44	3:42:57	41	65,85	9,76	4,85	90,24	

Хүснэгт 16. Лавлагааны чанарын үзүүлэлт /2017 оны III улирлын байдлаар/



Global Customer Service System © IPC

## EMS Customer Service Performance Consolidated Report

			As replying partner									
			Customer service response quality		Timeliness				Quality			
			On-time reply (0.5) 1 Level Resolution (0.25) Close cases (0.25)		On-time reply (EMS reply time standards)		Time to open requests received		Workflow Resolution		Workflow Duration (< 15 working days)	
IS	Country name	Region	%	#	%	working hours	#	%	%	working days	%	
MA	Morocco	Arab	94,35	388	99,74	1:04:07	317	83,28	3,47	3,21	94,64	
MD	Moldova	Europe	95,16	37	100,00	0:28:46	31	80,65	0,00	1,37	100,00	
ME	Montenegro	Europe	100,00	7	100,00	2:21:00	7	100,00	0,00	0,54	100,00	
MG	Madagascar	Africa	98,69	20	100,00	0:33:38	19	94,74	0,00	0,77	100,00	
MK	the former Yugoslav Republic of Macedonia	Europe	91,67	18	100,00	2:15:30	15	80,00	0,00	4,41	86,67	
MM	Myanmar	Asia Pacific	94,12	20	100,00	1:57:34	17	82,35	0,00	3,89	94,12	
<b>MM</b>	<b>Mongolia</b>	<b>Asia Pacific</b>	<b>97,62</b>	<b>23</b>	<b>100,00</b>	<b>0:07:07</b>	<b>21</b>	<b>90,48</b>	<b>0,00</b>	<b>1,57</b>	<b>100,00</b>	
MO	Macao (China)	Asia Pacific	94,89	113	100,00	0:19:23	93	82,80	3,23	2,15	96,77	
MR	Mauritania	Arab	82,14	18	100,00	3:56:08	7	42,86	42,86	6,1	85,71	
MT	Malta	Europe	57,63	87	45,98	64:49:50	70	81,43	4,29	13,99	57,14	

Хүснэгт 17. Лавлагааны чанарын үзүүлэлт /2018 оны I улирлын байдлаар/

Улаанбаатар хотын үйлчилгээний ажилтнууд, шууданч, олгогч, ялгагч, салбарын менежер, жолооч жууданч нарт “Харилцаа-үйлчилгээний стандарт”-ын хяналт мониторингийг хийж ажиллалаа. /Хүснэгт 18/

Салбарын менежерийн мониторингийн үзүүлэлт						
№	НЭРС	САЛБАР НЭГЖ	ИВЧЛЭГЧ ҮЙЛЧЛЭГЧ	ТӨ ГРАДУСААР ШАЛГАСАН	ОГНОО	ҮНДЭГЭЭНИЙ ХҮВЬ
1	Боловсрол	46 салбар	тайв	тайв	4/13/2018	26,20 100%
2	Өвчлөмж	7УС	тайв	тайв	3/12/2018	26,20 100%
3	Цэвэрлэгч	56 салбар	тайв	тайв	3/29/2018	15,43 100%
4	Урьтгал	44 салбар	тайв	тайв	3/30/2018	26,20 100%
5	Баталгаа	38 салбар	тайв	тайв	3/30/2018	26,20 100%
6	Министрийн	29 салбар	тайв	тайв	4/3/2018	26,20 100%
7	Агааржуулах	51 салбар	тайв	тайв	3/29/2018	26,20 100%
8	Урьтгал	34 салбар	тайв	тайв	3/28/2018	26,20 100%
9	Аруутгал	21 салбар	тайв	тайв	3/28/2018	26,20 100%
10	Министрийн	24 салбар	тайв	тайв	3/30/2018	26,20 100%
11	Вантуйн	40 салбар	тайв	тайв	3/29/2018	26,20 100%
12	Министрийн	29 салбар	тайв	тайв	3/29/2018	26,20 100%
13	Боловсрол	32 салбар	тайв	тайв	3/29/2018	26,18 98%
14	Хүндэтгэл	49 салбар	тайв	тайв	3/29/2018	26,18 98%
15	Солонгосын	33 салбар	тайв	тайв	3/27/2018	26,13 98%
16	Тасарын	48 салбар	тайв	тайв	3/13/2018	26,16 98%
17	Тасарын	23 салбар	тайв	тайв	4/3/2018	26,13 95%
18	Хатгал	36 салбар	тайв	тайв	3/30/2018	26,13 95%

Салбарын үйлчилгээний ажилтнуудын мониторингийн үзүүлэлт						
№	НЭРС	САЛБАР НЭГЖ	ИВЧЛЭГЧ ҮЙЛЧЛЭГЧ	ТӨ ГРАДУСААР ШАЛГАСАН	ОГНОО	ҮНДЭГЭЭНИЙ ХҮВЬ
1	Цэвэрлэгч	23 салбар	тайв	тайв	4/3/2018	30,30 100%
2	Ивчлэгч	38 салбар	тайв	тайв	3/30/2018	30,30 100%
3	Магистрийн	20 салбар	тайв	тайв	3/29/2018	30,30 100%
4	Ивчлэгч	13УС	тайв	тайв	3/12/2018	40,40 100%
5	Бая	46 салбар	тайв	тайв	4/13/2018	30,30 100%
6	Эхлэглэгч	44 салбар	тайв	тайв	3/30/2018	30,30 100%
7	Баталгаа	44 салбар	тайв	тайв	3/30/2018	30,30 100%
8	Умга	53 салбар	тайв	тайв	3/30/2018	30,30 100%
9	Баталгаа	36 салбар	тайв	тайв	3/30/2018	30,30 100%
10	Эхлэглэгч	26 салбар	тайв	тайв	4/3/2018	30,30 100%
11	Байгалийн	23 салбар	тайв	тайв	4/3/2018	30,30 100%
12	Сэрвэгч	7УС	тайв	тайв	3/12/2018	40,39 98%
13	Байгалийн	24 салбар	тайв	тайв	3/29/2018	30,29 97%
14	Баян	15 салбар	тайв	тайв	3/27/2018	30,29 97%
15	Өгөөмж	26 салбар	тайв	тайв	4/3/2018	30,29 97%
16	Ж.Огтоо	38 салбар	тайв	тайв	3/30/2018	30,29 97%
17	Аруутгал	46 салбар	тайв	тайв	3/13/2018	30,29 97%
18	Нарвунгаж	46 салбар	тайв	тайв	3/13/2018	30,29 97%
19	Нарвунгаж	29 салбар	тайв	тайв	3/30/2018	30,29 97%
20	Ивчлэгч	7УС	тайв	тайв	3/9/2018	40,38 95%
21	Эрхлэгч	30 салбар	тайв	тайв	3/29/2018	30,28 93%
22	Салбар	56 салбар	тайв	тайв	3/29/2018	30,28 93%
23	Магистрийн	48 салбар	тайв	тайв	3/29/2018	30,28 93%
24	Агааржуулах	51 салбар	тайв	тайв	3/29/2018	30,28 93%
25	Өгөөмж	7УС	тайв	тайв	3/12/2018	40,37 93%
26	Баталгаа	7УС	тайв	тайв	3/13/2018	40,37 93%

Хүснэгт 18. Мониторингийн үзүүлэлтүүд

Нэгж ажилтны ажлын гарцыг сайжруулах, байгууллагын соёлын түвшинг анхан шатанд тогтоох зорилгоор УБ хотын 200 орчим ажилтнаас судалгаа авч ажиллалаа. Энэхүү судалгаа нь цаашид ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд суурь судалгаа болох юм.

## **5.9. Хууль, эрх зүйн хэрэгжилтийг хангах ажлын талаар**

Компанитай холбоотой хууль эрх зүйн чиглэлийн бүх асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэн, компанийн үйл ажиллагаа, авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэсэн. Компанийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

2016 оны 10 дугаар сараас хойш компанийн хэмжээнд байгуулагдсан гэрээ хэлцлийн хууль зүйн хүчин төгөлдөр байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болохуйц нөхцөл байдал бий эсэх зэргийг шалгаж, шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээнээс бусад харилцааг зохицуулсан нийт 98 ширхэг гэрээнд дүгнэлт гаргаж ажилласан. Бараа ханган нийлүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 89 аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан ажилласан ба гэрээний хяналт, үүргийн гүйцэтгэлд холбогдох ажилтантай хамтран хяналт тавьж, шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээний загварт компанийг эрсдлээс хамгаалах үүднээс 2 зүйл заалтыг шинэчилсэн. Гэрээнд хяналт хийхдээ зарим зүйл заалтыг хасах, өөрчлөх, шинэчлэн найруулах, гэрээ байгуулахаас татгалзах зэргээр хяналт хийснээс гадна гэрээг шинэчлэн боловсруулах байдлаар хяналтыг хэрэгжүүллээ.

Ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ тухайлбал, аймгуудын ШҮГ-ын даргатай байгуулах хөдөлмөрийн гэрээ түүнтэй холбогдох бусад гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулан ажиллалаа. Цаашид хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, А. Б тушаалын нэгдсэн эхийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөхөөр ажиллаж байна.

Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй журмуудад 5 асуулга бүхий судалгаа тандалт хийж, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, нэгтгэн найруулах, шинээр боловсруулах, хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийг тусгах гэж ангиллаа.

“Хөдөлмөрийн дотоод журам”, “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам”, “Ажлын цаг ашиглалт, хяналт тавих журам”, “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журам”, “Аттестатчиллын журам”, “Сургалт хөгжлийн журам”, “Ёс зүйн дүрэм”, “Албан хэрэг хөтлөх журам”, “Архивын журам”-ын эцсийн хэлэлцүүлэг хийгдэхэд бэлэн болсон байна.

Гэрээ байгуулах, хянах журам”, “Нууцын тухай журам”, “Албан томилолтын журам”, “Тэтгэмж, буцалтгүй тусламж олгох журам”, “Шагнал урамшуулал олгох журам”, “Чөлөө авах журам”-ыг төслийн хэмжээнд хянан боловсруулаад байна.

Зэрэг дэв олгох ажлын хэсгийн ажил түр хойшлогдсонтой холбоотой “Зэрэг дэв олгох журам”-ын эцсийн байдлаар хийгдэхгүй хүлээгдэж байна.

Компанийн ажилтнуудад шаардлагатай хууль эрх зүйн зөвлөгөө тусалцааг тухай бүрт өгч ажилласан.

Чингэлтэй дүүргийн цэргийн штабаас Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд байгууллага дээр шалгалт явуулсан бөгөөд компанийн 18-50 насны бүх эрэгтэй ажилтнуудын судалгааг гарган, цэргийн бүртгэлийг хийлгэсэн.

## **5.10. Аж ахуй, үйлчилгээний ажлын талаар**

### **5.10.1. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ**

Шуудангийн үйлчилгээний танхим, албан тасалгаануудад, ажлын байр, ариун цэврийн өрөө болон гаднах орчинг хоггүй, цэвэр байлгах зорилгоор төв байр, Марк, үнэт цаасны хэлтэс, дугтуйны үйлдвэрийн байруудын үйлдвэрлэл үйлчилгээний болон албан тасалгаануудын цэвэрлэгээг өдөр тутам хийхээс гадна “Монголын цахилгаан холбоо” компанитай хамтарч, долоо хоног бүрийн Пүрэв гарагт гадна талбай болон үйлчилгээний төв заалны гадна шат, шил, цонхыг тогтмол цэвэрлэж хэвшлээ. /Зураг 34/




*Зураг 34. Гадна талбайг цэвэрлэж байгаа нь*

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2018 оны дөрөвдүгээр сарын 21-нд “Их хотын их цэвэрлэгээний 90 минут” уриатайгаар бүх нийтийн их цэвэрлэгээний хүрээнд төв байр болон бүх салбар нэгжүүдэд их цэвэрлэгээ хийх ажлыг амжилттай зохион байгууллаа. /Зураг 35/



*Зураг 35. Их хотын их цэвэрлэгээний 90 минут*

Шуудангийн үйлчилгээний салбаруудын дуудлагаар нийт сантехникийн 58, цахилгааны 76, мужааны 86 засварын ажлуудыг хийснээс гадна, төв байрны 380в, дугтуйны үйлдвэрийн 380в-ийн цахилгааны газардуулгын ажил, мөн лифт, конвейрын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэлээ. /Зураг 36/



*Зураг 36. Засварын ажил хийж байгаа нь*

Өөрсдийн дотоод нөөц бололцоогоор 5 давхрын хуучин өрөөний засал чимэглэлийн ажил, ШҮ-ний 56 дугаар салбарын галд өртөн шатсан байрыг яаралтай сэргээн засварлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан бөгөөд НШШГЕГ-ын хүлээлгийн танхимд ШҮ-ний 28а дэд салбарыг нүүлгэн шилжүүлж байршуулах, шинээр лангуу тейк хийх ажлуудыг хийв.

ШҮ-ний 25 дугаар салбарын түрээсийн шинэ байранд шинэ төмөр хаалга суулгах, дотор засал чимэглэл, сантехникийн холболтууд, шинээр суултуур суулгах ажлууд, 20, 26-р салбарын хуучин хагархай суултуурыг шинээр сольж суурилуулах ажлууд хийгдлээ. /Зураг 37/



*Зураг 37. Засал чимэглэл, сэргээн засварлах ажил*

Улаанбаатар хотын бүх салбаруудын 148 ширхэг жинг Стандарт хэмжил зүйн газарт захиалга өгч, жин хэмжүүрийн ажилтантай хамтран баталгаажуулалт хийлээ.

Авто баазад хийгдсэн их цэвэрлэгээний ажилд үндсэн хөрөнгийн нягтлан бодогч, автын механик, шууданч-жолооч нартай хамтран, актлагдсан, ашиглах боломжгүй тавилга эд хөрөнгийг зурагжуулан бүртгэж, устган цэгцэлсэн.

Мэрэгч хортон шавьж устгалын "ТОТКОМ" ХХК -тай хийсэн гэрээний дагуу компанийн төв байрны 1, 2, 3-р давхрын албан тасалгаа болон үйлдвэрлэл үйлчилгээний байрууд, ариун цэврийн өрөө, агуулах, Марк, үнэт цаасны хэлтэс, дугтуйны үйлдвэрийн байруудад улиралд нэг удаа хор цацуулан ажиллаж байна. /Зураг 38/



*Зураг 38. Мэрэгч хортон шавьж устгалын ажил*

### **5.10.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй**

Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хороотой 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллаж, 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн сайн үйлсийн өдөрлөгөөр 118 ажилтныг гишүүнээр элсүүлэн, үнэмлэхийг нь гардуулж өгсөн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд “Амилуулах суурь тусламж үзүүлэх практик сургалт”-ыг зохион байгуулж, нийт 276 ажилтнууд хамрагдлаа. /Зураг 39/



*Зураг 39. Амилуулах суурь тусламж үзүүлэх практик сургалт*

Анхны тусламж үзүүлэх 15 хүний бүрэлдэхүүнтэй нөхөрлөлийн бүлгэм байгуулж, цогц практик сургалтанд хамруулсны зэрэгцээ анхны тусламжийн иж бүрдэл багаж хэрэгслээр хангасан. /Зураг 40/



*Зураг 40. Анхны тусламж үзүүлэх нөхөрлөлийн бүлгэм*

Төрийн өмчит ХАБЭМ төвтэй ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн ерөнхий мэдлэгийн хүрээн дэх сургалт, ажлын байрны эрсдэл тодорхойлох болон цаашид анхаарах зөвлөмжийн талаар 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр сургалт зохион байгууллаа./Зураг 41/



*Зураг 41. Хөдөлмөрийн нөхцлийн ерөнхий мэдлэгийн сургалт*

Онцгой байдлын ерөнхий газар болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хамтарсан “Газар хөдлөлтийн гамшигийн үеийн холбоо зохион байгуулалт” сэдэвт дадлага сургуульд 2018 оны 5 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд баг хамт олноороо амжилттай оролцлоо. /Зураг 42/



*Зураг 42. “Газар хөдлөлтийн гамшигийн үеийн холбоо зохион байгуулалт” сэдэвт дадлага сургууль*

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвөөс 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 16:00 цагт зохион байгуулсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг”-ийн дадлага сургалтанд 88 ажилтан оролцсон байна.





Тус компанид гамшгийн аюулын тухай эхний дохиогоор газар хөдлөлтийн үеийн аюулгүй ажиллагааны “Нуугд-Суу-Хүлээ” зарчмыг баримтлан, өрөө тасалгаандаа аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээг авч, ширээн доогуур орох, даацын хана, булан тохойд зогсох дадлага, хоёр дахь дохио дуугарсны дараа барилга, объектыг орхин гарахдаа гараараа болон гарын доорх зүйл ашиглан толгойгоо хамгаалан, “Гүйхгүй, Хашгирахгүй, Түлхэлцэхгүй, Эргэж буцахгүй” гэсэн зарчмаар барилгын аврах гарцаар гарч, аюулгүй зай талбайд цугларах дадлага, сургуулилтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. /Зураг 43/



*Зураг 43. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, танцуулах өдөрлөг”-ийн дадлага сургалт*

Тэмдэглэлт өдрүүд, спортын арга хэмжээний үеэр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тухай бүр өгч ажиллалаа.

Гал түймэрт шатсан ШҮ-ний 56 дугаар салбарын гадны нөлөөнөөс болж гал гарсан тухай дүгнэлтийг захирлын зөвлөлд танилцуулж, цаашид тухайн сууцыг дахин ашиглахгүй байх талаар тодорхойлолт гаргаж өглөө.

Замын-Үүдийн логистикийн төвийн ажлын байрны нөхцөл болон үйл ажиллагаатай танилцаж, зааварчилгаа өгч ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газраас аюулын дохиоллыг биедээ байнга авч явж байхыг зөвлөсөн зөвлөмжийн дагуу 10 ш дохиоллыг гэр хорооллоор хүргэлт хийдэг шууданчдад өгч, туршилт хийж байна.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс Шастины нэрэмжит нэгдсэн III нэгдсэн эмнэлэгийн хоол боловсруулах эмгэгийн тасагт 2 ортой өрөөг тохижуулан, эмнэлэгт зайлшгүй хэвтэн эмчлүүлэх шаардлагатай болон хэвтэн эмчлүүлэх хүсэлтэй ажилтнуудыг дугааргүй, үнэ төлбөргүй эмчлүүлж байхаар тохирсон.

Ажилтнуудыг чөлөөт цагаа ашиглан хөдөлгөөний дутагдлаас гарах, өөрсдийгөө хөдөлгөөнтэй байлгах үүднээс дагаж хийх боломжтой бүтэн 2 цагийн биеийн булчин

хөгжүүлэх дасгалыг өдөр бүр дэлгэцээр гаргаж байна. Мөн булчингийн массыг нэмэгдүүлэх дасгалын арга техникийг зургаар үзүүлэн хананд өлгөсөн .

Нийт давтагдсан тоогоор 300 гаруй ажилтанд өдрийн эмийн эмчилгээ болон уламжлалт эмчилгээг стандартын дагуу хийж үйлчилсэн. Олон давтамжтай эмчилгээ хийлгэж байгаа буюу суурь өвчтэй ажилчдад өвчний болон эмчилгээний явцыг хянан карт нээн ажилласан. Ингэснээр өвчтөн үр дүнд хүрсэн эмчилгээгээ цаг алдалгүй давтан хийлгэх боломжтой юм.

## ЗУРГАА. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД

### 6.1. Марк, үнэт цаасны үйлдвэрлэлийн талаар

Тус компани нь 2018 оны эхний хагас жилд шинээр дараах 6 сэдвийн шуудангийн маркийг шуудангийн үйл ажиллагаанд гарган сурталчлах, түгээх, борлуулах, мөн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Үүнд:

- “Нохой жил”
- “Мэргэжлийн уулын спорт МУГТ Б.Гангаамаа”
- “Монгол үндэсний идээ ундаа”
- “Ц. Дамдинсүрэн- гэр музей”
- “Хүүхдийн зураг”
- “Монголчуудын бичиг үсэг”

“Монголын үзэсгэлэнт газрууд” сэдвийн маркийг хэвлэлтэд шилжүүлэн, үнийн саналыг хүлээн авч зөвшөөрлийг олгон дардсыг хүлээн авахад бэлэн болоод байна.

“Эрдэнэт үйлдвэрийн-40 жилийн ой” сэдвийн өндөр технологийн маркийн судалгаа, гар зураг, дизайныг хийж гүйцэтгэн, Франц улсын марк үнэт цаасны хэвлэлийн газарт илгээгээд байна.

Тайлант хугацаанд 6 төрлийн 529,4 мянган ширхэг дугтуйг, 192,81 мянган ширхэг анхан шатны маягт болон бүртгэлийн дэвтэр, 326,89 мянган хуудас /RD, SP, LG, CD, EE/ бар кодууд, 3,05 ширхэг анхны өдрийн дугтуй, 360 мянган ширхэг мөнгөний дугтуйг үйлдвэрлэж, аймаг, салбар, нэгжүүдээр худалдаалах болон шуудангийн дотоодын хэрэгцээнд нийлүүлсэн. /Хүснэгт 19/

д/д	Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө мян/ширхэг	Үйлдвэрлэсэн мян/ ширхэг	Биелэлт /%/
1	C4 дугтуй	135	147.6	109.3
2	C5 дугтуй	130	149.5	115.0
3	C6 дугтуй	60	29.1	48.5
4	DL дугтуй цонхтой	276	167.4	60.7
5	DL дугтуй цонхгүй	70	35.8	51.1
6	Мөнгөний дугтуй /14 шинэ+ 8 хуучин загвар/	200	360	180.0
7	Анхан шатны бүртгэлийн маягт, дэвтэр	320	192.81	60.3
8	RD, RC, EE, LG, SP кодууд	170	326.89	192.3
9	АӨД		3,05	

Хүснэгт 19. Дугтуй, анхан шатны маягтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт

### 6.2. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаар

“Монгол Шуудан” ХК нь өөрийн хөрөнгөөр 7,9 тэрбум төгрөгийн 104 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, үүнээс 1,2 тэрбум төгрөгийн 31 их засвар, худалдан авах ажлыг гүйцэтгэж, нийт худалдан авалтын 30 хувийг гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Сангийн сайдын баталсан тендер шалгаруулалтын жишиг бичиг, баримтын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

SDR, ам долларын ханшинд харьцуулалтын судалгаа хийж, валютын ханшны гарч болзошгүй эрсдэлээс хамгаалан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас худалдан авах ажиллагааны үйл явцыг хурдан, шуурхай олон нийтэд хүртээлтэй, ил тод, нээлттэй зохион байгуулж, “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-ийг ашиглан, [www.tender.mn](http://www.tender.mn) сайтад 2018 онд тус

компанид хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг цаг тухай бүрт нь бүртгүүлэн байршуулж байна.

Мөн шилэн дансны хуулийг дагаж мөрдөн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, Сангийн яамны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад мэдээллийг сар, улирал бүр байршуулсан.

### **6.3. Дотоод хяналт шалгалтын талаар**

Нийслэлийн ШҮ-ний салбаруудын посын програмын ашиглалтад нийт 13 хоногийн хугацаатай хяналт шалгалт хийхэд зарим салбар посын програм нь санхүүгийн програмтай холбогдоогүй, марк уншуулахад гацаад цаг хугацаа алдаж, харилцагчийг удаан хүлээлгэх зэрэг зөрчил дутагдал илэрсэн.

Сүхбаатар, Хэнтий, Багануур, Эрдэнэт, Дархан, Дундговь, Өмнөговь аймгийн ШҮГ-уудын 2016-2017, 2018 оны эхний хагас жилийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд нийт 17 хоногийн хугацаатай хяналт шалгалт хийлээ.

“Монгол шуудан” ХК-ийн ажиллаж буй газар, хэлтэс, албаны үйл ажиллагааны тайлан, түүний биелэлтэд хяналт тавин ажиллаж, шалгалтын тайланг захирлын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн боллоо.

## ДОЛОО. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

“Монгол шуудан” ХК нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

JCI Central байгууллагаас хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтэц үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх “Тэгш боломж” төсөлд нэгдэж, хамтран ажиллах санамж бичиг үзэглэлээ. /Зураг 44/



Зураг 44. Санамж бичиг үзэглэж буй нь

Учрал охины эмчилгээний зардлыг босгоход зориулсан “Том сэтгэл” аянд нэгдэж, 2,000 ширхэг ил захидлыг үнэгүй хандивлан, түүнд компанийн зүгээс эрүүл энх, сайн сайхныг хүсч, олон нийтийг уриаллаа. /Зураг 45/



Зураг 45. Учрал охины ар гэрт ил захидал гардуулж байгаа нь

“World Learning” төрийн бус байгууллагатай хамтран, “Ил топ байдал залуусын нүдээр” төсөлд нэгдэж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан авлига, ил тод байдлын тухай сургалтын хэрэглэгдэхүүнийг Монгол орон даяар, аймаг сумдын 730 гаруй сургуульд үнэ төлбөргүй хүргэхээр хамтран ажиллах санамж бичгийг үзэглэлээ./Зураг 46/



Зураг 46. Санамж бичиг үзэглэж буй нь

Цогц хөгжлийн үндэсний төвтэй хамтран, "Мэргэжлийн цагаан толгой" нэвтрүүлгийн 500 гаруй ширхэг DVD-г орон нутгийн 500 гаруй ЕБС-дад 14 хоногийн дотор үнэгүй хүргэн гардуулж, талархал хүлээж ажиллалаа./Зураг 47/



Зураг 47. DVD болон талархал

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**2017.12.31**

Мөнгө	26,659.3	БХӨТ	19,435.2
Бусад хөрөнгө	14,192.9	Эздийн өмч	21,417.0
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,852.2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>40,852.2</b>

[Нэгж: сая ₮]

[Нэгж: сая ₮]

**2018.06.30**

Мөнгө*	13,247.73	БХӨТ**	6,340.46
Бусад хөрөнгө	14,951.63	Эздийн өмч	21,858.9
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,199.36</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>28,199.36</b>



Өөрчлөлт

\*Мөнгө – Транзит үйлчилгээтэй холбоотой үлс хоорондын тооцооны төлбөр төлсөнтэй холбоотой бууралт

\*\*Богино хугацаат өр төлбөр – Транзит үйлчилгээтэй холбоотой үлс хоорондын тооцооны төлбөр төлсөнтэй холбоотой бууралт

## ОРЛОГЫН ТАЙЛАН


[Нэгж: сая ₮]

№		2017.06.30	2018.06.30	ӨСӨЛТ	
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,899.34	7,792.64	1,893.29	132.1%
2	Борлуулалтын өртөг	5200.53	6,708.23	1,507.70	129.0%
3	Нийт ашиг (алдагдал)	<b>698.81</b>	<b>1,084.41</b>	<b>385.59</b>	<b>155.2%</b>
4	Түрээсийн орлого		50.97*	50.97	
5	Хүүний орлого	799.68	402,34	(397.34)	50.3%
6	Ерөнхий ба удирдлагын зардал	319.81	467.92	148.11	146.3%
7	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(475.9)	31.25	507.18	
8	Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз (гарз)				
9	Бусад ашиг (алдагдал)	(35.99)	(65.01)	29.02	
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	<b>666.75</b>	<b>1,036.85</b>	<b>370.10</b>	<b>155.5%</b>
11	Орлогын татварын зардал	63.14	130.18	67.03	206.2%
12	Татварын дараах ашиг (алдагдал)	<b>603.61</b>	<b>906.68</b>	<b>303.07</b>	<b>150.2%</b>

\*Өмнө тайлангаар борлуулалтын орлогод бүртгэгдэж явдаг байсан орлого



## НИЙТ ОРЛОГЫН ӨСӨЛТ /сая ₮/



## НИЙТ ОРЛОГО 8,273.1 САЯ ТӨГРӨГ

2018 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулбал 65% буюу 3,277.2 сая₮-р өссөн байна

Нийт орлогын хувьд 2018 ба 2017 мөн үеийн гүйцэтгэлийг харьцуулбал 23% буюу 1,989.17 сая ₮-р өссөн байна

Эхний хагас жилийн төлөвлөгөөг 7.64% буюу 587.34 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна

### НИЙТ ЗАРДАЛ:


Сүүлийн 3 жилийн дундаж өсөлт	21%
2018/2017 өсөлт	31%
2018/2015 өсөлт	65%

## ОРЛОГЫН БҮТЭЦ (2017 ба 2018)


Эхний хагас жилээр

[Нэгж: сая ₮]

№	Орлого бүтэц	2017 гүйц	2018 гүйц	Өсөлт
1	Үндсэн үйлчилгээ	3,943.0	4,245.1	302.1
2	Логистик үйлчилгээ	170.6	291.9	121.3
3	Транзит үйлчилгээ	649.7	2,626.3	1,976.6
4	Бусад нэмэлт үйлчилгээ	721.0	707.4	(13.5)
5	ҮА-ны бус орлого	799.7	402.3	(397.3)
	<b>Нийт орлого</b>	<b>6,283.9</b>	<b>8,273.1</b>	<b>1,989.2</b>



## НИЙТ ЗАРДЛЫН ӨСӨЛТ/сая₮/



### Өөрчлөлт

## НИЙТ ЗАРДАЛ 7,241.17 САЯ ТӨГРӨГ

2018 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулбал 55% буюу 2,586.83 сая₮-р өссөн байна.

Нийт зардлын хувьд 2018 ба 2017 мөн үеийн гүйцэтгэлийг харьцуулбал 30% буюу 1,699.94 сая ₮-р өссөн байна

Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт 101% ба 115.04 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй байна

### НИЙТ ЗАРДАЛ:

Сүүлийн 3 жилийн дундаж өсөлт	18%
2018/2017 өсөлт	30%
2018/2015 өсөлт	55%

## ЗАРДЛЫН БҮТЭЦ (2017 ба 2018)

Эхний хагас жилээр

[Нэгж: сая ₮]

№	Зардал бүтэц	2017 гүйц	2018 гүйц	Өсөлт
1	Цалин, НДШ	2,838.19	3,456.02	617.84
2	Тээвэр, шатахуун	1,107.96	1,835.84	727.88
3	Хөрөнгийн ашиглалт	817.19	831.11	13.92
4	Удирдлагын зардал	319.81	467.92	148.11
5	Бусад зардал	458.07	650.27	192.20
<b>Нийт зардал</b>		<b>5,541.23</b>	<b>7,241.17</b>	<b>1,699.94</b>

\* Нийт ажилчдын цалингийн өсөлт 2017/08 2018/01-04

\*\* Транзит тээврийн зардлыг бүртгэдэг болсонтой холбоотой

\*\*\* Удирдлагын баг орон тоо бүрэн болсонтой холбоотой

